



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



# ХУУЛЬ ЁС ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,  
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

# ЭНЭ ДУГААРТ:

## Төрийн байгуулалтын хууль тогтоомж

**Хүний нэр төр, алдар хүнд ба Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт**  
(Докторант Ш.Сүхбаатар) 3-4

**Ерөнхийлөгчийн институтэд эрх зүй ёсны үүднээс хандах нь**  
(МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Ч.Өнөрбаяр) 5-8

**Монгол дахь хууль дээдлэх ёсны төлөвшил - онгөрсөн, одоо, ирээдүй**  
(Улсын Их Хурлын Тамын газрын ажилтан Э.Ганболд) 9-10

**Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх**  
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Оросоо) 11-13

**Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад анхаарах зарим асуудал**  
(МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант Ж.Жавзандулам) 14-16

**Хуулийн тайлбар**  
(Жайка-ийн эрх зүйн шинэштэг, туслацаа төслийн мэргэжилтэн Танабэ Масанори) 17-18

**Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба Олон нийтийн хэвлэл мэдээлэл**  
(МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант М.Батсуур) 19-25



## Прокурорын хяналт

**Хориг ял эдлүүлэх зарим тulgамdsan асуудал**  
(ҮЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэсийн хяналтын прокурор Ц.Мөнхбат) 26



## Криминологи

**Шилжилтийн үеийн Монгол Улс дахь гэмт хэргийн чиг хандлага**  
(ХЗҮТ-ийн Криминологи судалгааны секторын эрхлэгч Д.Зүмбэрэлхам) 27-28



## Иргэний хууль тогтоомж

**Өөртөө туслах нь өөрийн хамгаалалтын арга болох тухай асуудалд**  
(ТЭГ-ын Дээд сургуулийн багш, дэд профессор Д.Бат - Өлзий) 29-30

**Арбитрын ажиллагааны нууцлалын зарим асуудал** (ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч Ц.Цолモン) 31-36

## Иргэний хуулийг тайлбарлах нь

(Цуврал ) 37-50

**Шударга өрсөлдөөн - бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлнэ**

(Шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах газрын дарга Б.Жаргалсайхан) 51-52



Олон улсын эрх зүй,  
харьцуулсан эрх зүй

**БНХАУ дахь хүний эрхийн төлөв байдал**

(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Энх - Амгалан ) 53-60

**ОХУ-ын хязгаарлагдмал**

**хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал**

(ХЗҮТ-ийн Сургалтын төвийн багш, магистр Т.Жаргалсайхан )

61-64

**Латин нэр томъёоны тайлбар**

(Цуврал ) 65-69

**Авиалгалын эсрэг НҮБ-ын конвенц ба Монгол Улсын үндэсний хууль тогтоомж : Уялдуулах арга зам**

Академич.доктор, профессор Ж.Амарсанаа

Доктор, профессор Д.Зүмбэрэлхам

Магистр Ч.Нарантуяа

70-75



## Эрх зүйн үйлчилгээ

**Гэрчилж буй гэрээслэлээ сар бүр гэрчилж байх ёстой**

(Монголын нотариатын танхимын Мэдээллийн албаны ажилтан П.Отгонжаргал ) 76-78

**Мэргэжлийн нотариатын эрх зүй**

(Свердловск музкийн нотариатын танхимын эрхнэхийлэгч В.В.Ярков) 79-82



## Цаг үе, үйл явдал

**Ажил үйлсээрээ нэрээ мэнхөлсэн хүн - Генерал А.Думбурай**

(ЦЕГ-ын ажилтан, хурандаа Л.Билгээ ) 83-85



## Мэдээ, мэдээлэл

**Шинэ ном**

86-87

# Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүн:

Ц.Бат-Орших Сэтгүүлийн зөвлөлийн ерөнхий эрхлэгч

## Гишүүд :

Б.Бат-Эрдэнэ

Л.Бямбаа

Н.Дагва

А.Доржотов

Л.Заяа

Д.Мөнхгэрэл

Э.Лхагвасүрэн

Д.Наранчимэг

А.Оюунчимэг

Т.Уранцэцэг

Ш.Үнэнтэгс

Б.Пүрэвням

Роберт Ла Монт

Ж.Сайнжаргал

Я.Сайнжаргал

Б.Цэрэнбалтав

Б.Чимид

А.Энхжав

- Цагдаагийн академийн дээд захирал
- Нийслэлийн шүүхийн шүүгч
- Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга
- Улсын дээд шүүхийн шүүгч
- ГТХАН-ийн ХСДСТ-ийн удирдагч
- ХЗДХЯ-ны газрын дарга
- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
- Отгонцэнгэр их сургуулийн ректор
- Монголын нотариусын танхимиын ерөнхийлөгч
- Сонгинохайрхан дүүргийн ерөнхий шүүгч
- ХЗДХЯ-ны мэргэжилтэн
- Монголын юмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч
- АНУ-ын ОУХА-ийн "ШЭМШИ"-ийн удирдагч
- Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын ажлын албаны дарга
- Улсын ерөнхий прокурорын орлогч
- ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор профессор
- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга

Дугаарыг эрхэлсэн: С.Дэлгэрзаяа

(Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга)

Ц.Ариунжаргал

(Сэтгүүлийн ажилтан)

Эрхлэн гаргагч: Хууль зүйн үндэсний төв

Редакцын хаяг : Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7

Утас : 322094, 315736 Факс:322094

Вэб сайт: [www.legalcenter.mn](http://www.legalcenter.mn)

И-мэйл: Huuli\_deedleh\_yos@yahoo.com

Улсын Бүртгэлийн дугаар: 279

## Хүний нэр төр, алдар хүнд ба Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт



Доктрант Ш.Сүхбаатар

Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон улсын болон бус нутгийн хэмжээнд олон улсын конвенцфор, дотооддоо Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудаар баталгаажуулж ирснийг эрдэм судлалын хүрээнд судалж, дүгнэх нь чухал шаардлагатай тедийгүй эрх зүйн шин тогтолцоог улам болсовренгүй болгоход ихэзэн ач холбогдолтой билээ.

Бидний өвгөд дээдээс хүнийг "Түмэн бодисын охь, мянган амьтны манлаг" гэх буюу "Хүн нэмбэл хүнс нэмнэ" гэхчилэнгээр дээдэлж, түүний нэр төр, алдар хүндийг хүлээн зөвшөөрж эрхэмлэсэн нь Монгол Улсын 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын нэг хасгыг юм.

Ийнхүү нэр төрөө эрхэмлээн дээдэлжих сахин хамгаалах үзэл болд бол хүн төрөлхтний нийтийг ойлголт бөгөөд олон орны Үндсэн хуулинд энэ үзэл санаа тусгалаа олон байдал байна. Тухайлбал: Герман улс Үндсэн хуулийнхаа 1.1-д "Хүний нэр төр, эрхэмсэг оршихий" (*Menschenwürde*)-д хандаж болохгүй. Хүний нэр төрийг

хүндэтгэх нь төрийн үүрэг" хэмээн хүний мөн чанар, түүний үзүү цэнийг онцгойлон тодотож, иргэний хүсэл, мөрөдөл, нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэхийг төрдөө хууль болгосон байна.

Манай улсын хувьд ч хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах үзэл санаа нь эрт дээр үеэс уламжлагдан ирсан нь тухайн цаг үеийнхээ "Үндсэн хууль"-ийн хэмжээнд тооцож болохуйц хууль цаазны бичгүүдэд тусгалаа олж иржээ.

"Монголын нууц товчоо"-ны баримтуудыг түшиглан үзвээс Чингис хаан Уйгурын Идууд хаанд Алантүн Бэхжи охиноо зарлиглан хатан болгож өгөөд "Хатагтай хүнд гурван эр бий. Ахны эр нь алтан төр, дараахь эр нь ариун нэр, түүний дараахь эрнэ авсан эр мөн. Алтан төрийн хатуужиж дагавал ариун нэртэй болно. Ариун нэрийг бэхжэлэв авсан эр анигиуудыг үл одно" хэмээн сургалжилсан нь их л гүн утга санаа агуулсан белгээ.

Чингисийн толгойлон хант төрд иргэдийн амь бие, нэр төрийн эсрэг үйлдлийг гэмт хэргэг эзж узж байсныг хууль зүйн шинжлэх ухааны доктор И.Дашням "Чингисийн хаант улсын төр, хууль цаазын" бүтээлдээ тэмдгэлжээ. Гэвч дээрх заалт нь Чингисийн хаант засаглал, түүний тэрүүнийг бие махбод, удам угсаа, эрх мэдэл, нэр төрийг гэмт хандлагаас хамгаалсан шинжтэй байсан байна.

Монголчуудын нэр төр, алдар хүндээс хамгаалах зан шиншил нь ниймжийн бүх гишүүдийн ашиг сонирхлыг илэрхийлж, үеийн үед уламжлагдан, ниймжэд ашиг тустай зан үйлийн горимуудыг бэхжүүлж ирсэн байна.

Нэлээд хожуу үед зан заншлын хажуугаар тухайн нийгмийнхээ онцлогийг тусгасан шударга ёс, сайн муугийн тухай төсөөлөл, шашны болон ёс суртахууны хэм хэмжээнүүд бий болик эхэлсан байна.

Ёс суртахуун, шашны зан үйлээр болжидсан зан заншил нь аажмаар хэм хэмжээний бүхэл бүтэн цогц болон хувирж иржээ.

Тэдгээрийн хамгийн томоохон нь буюу "Үндсэн хууль"-ийн хэмжээнд тооцож болохуйц 1640 оны "Монгол-Ойрадын цааз бичиг", 1709-1795 оны хооронд халхын хаад ноёд, төр шашны том зүтгэлтнүүд хори гаруй удаа хуралдааж хэлэлцэн тогтоосон "Халх журам" хуулиудад нэр төр, алдар хүндийг зөвхөн ардын сургаалын номполоор сургаад зогссонгуй хуульчлан журамлаж байжээ.

Тухайлбал, 1640 оны "Монгол-Ойрадын цааз бичиг"-т:

- ❖ Хүн гутгэсэн тайж тавнанг таван есөөр торгох,
- ❖ Ноёдыг гутгэсэн харцыг долоон есөөр торгох,
- ❖ Их ноёндыг доромжилбл цазаар авах,
- ❖ Дунд ноёндыг доромжилбл нэг ес авах,
- ❖ Банди нарыг доромжилбл тав авах тухай заажээ.

Монголын хууль цаазын болон түүхийн нэн чухал баримт бичиг "Халх журам"-ын зургадугаар бүлэгт "Хүн гутгэж" нэр төрд нь халдаасаа хүлээгэх хариулагын тухай хуульчилж өгсөн байна. "Халх журам" хуулийн 118 дугаар зүйлд :

<sup>1</sup> И.Дашням. "Чингисийн хаант улсын төр, хууль цааз" УБ 1997.172 дахь талд

• Гүхэрээр худал уг айлтаваас ноёдиг бол тэмээз тэргүүлэн долоон есөөр тороо. Үүний таван есийг санд, хоёр есийг гүжирдуулэгчид ёг.

• Тайж тавнангуд бол тэмээз тэргүүлэн таван ес, үүний турван ес бүхэл болоод есийн хагас дөрвийн санд, нэг бүхэл ес болоод есийн хагас тавыг гүжирдуулэгчид ёг.

• Харц хүн бол тэмээз тэргүүлэн турван ес, үүний хоёр есийг санд, нэг есийг гүжирдуулэгчид ерөх ялтад хариулагчад тухай заалт оруулжээ.

Үүнээс үзвэл хүний нэр тэр, алдар хүндэд хамгалах нөхцөлд тухайн үеийн нийгмэд эзлэх байр сууриар ангилаан ялагвартай хариулгалаа оногдуулан, гүжирдүүлэгчид учирсан гэм хорын хохирлыг гаргуулсан олгох, ихэнх хэсгийн төрийн санд хуримтуулласаа хэлбэрээр шийдвэрлэж, байжээ.

Үүнээс хойш Улсын Ахидгаар Их Хурлаар 1924 онд батлагдсан Монгол Улсын Ахидгаар Үндсэн хууль нэр тэр, алдар хүндэтэй холбоотой тухайлсан заалт ороогүй ба "Сонгох, сонгогдох эрхийн тухай" деревэдүүээр бүлгийн 35 дугаар зүйлийн 5-д "Эд хичээх зэрэгээр нэрийг гутаах явдлыг үйлдэж загра шүүх газраас ял шийтгэгээд" аливаа хурлын төвлөгөөгчөөр сонгох, сонгогдох эрхгүй болохыг зааж өгчээ.

1940 оны Үндсэн хуулийн аравдугаар бүлэгт "Ард иргэний үндсэн эрх, үүргүүд"-ийг зааж эсгэн ч нэр тэр, алдар хүндтэй холбоотой тухайлсан заалт оруулаагүй байна.

1960 оны Үндсэн хуулийн додлугаар бүлэгт "Иргэдийн үндсэн эрх ба тунүүг хангах баталгаа"-г зааж өсгэн ч нэр тэр, алдар хүндтэй холбоотой тухайлсан

заалтгыг мэн л оруулаагүй явж иржээ.

Гэтэл хүний нэр тэр, алдар хүндийг хамгалах асуудал нь эдүгээгийн хөгжилтэй орнуудад ХҮII-ХҮIII зуунд хантай засгийн эсрэг өрнөсэн тэмцэл, хувьсгалын явцад тэр үеийн нийгмийн тэргүүний хүчинээс өнө эртний сэргэгчдийн давшүүлсэн үзэл санааг хувьсгалын түүхээр төсөөлжээ. Монгол Улсын гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан бичсэн өгүүлэлдээ онцлон тэмдэглэжээ.

Майн улс 1961 онд НҮБ-ын буран эрхтийнхүүн нэг бол уг байгууллагаас баталсан "Хүний эрхийн түзээлт тунхгялп", 1974 онд албан ёсоор нэгдэн орсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт" зэрэг энэ талаараа олон улсын бусад гэрээ бичигчүүдийг хүлээн зөвшөөрсөн атлаа өмнөх Үндсэн хуулиуддаа өөрөөр шийдсэн хэвээрээ байсан юм.

Шинэ Үндсэн хууль 1992 онд лэн байдлыг өөрчилж хүнийг иргэний нийгмийн харилцааны төв, улс орхын хувь заланы хинжнээзэн болгож, Монгол орчны олс төрийн уур амьсгалын олон улсын жишигт нийцүүлэхдэд томоохон алхам хийсний судлаачид зүй ёсоор үзэлсэн билээ.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн "Хүний эрх, эрх чөлөө"-г тунхгяласан хөдөрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 16.13-д "Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүннэг бус, хэрцгийн хандаж, нэр төрийг нь гутаан доромжилж болохыг" хэмээжээ.

Мен зүйлийн 13 дахь хэсэгт ийнхүү хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хуульчлан бэхжүүлсэн бөгөөд зөвхөн нэр тэр тедийгүй хүний бие, эд хөрөнгө, хувийн болон ээр бүлүүдийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй эрхийг албан тушаалтан болон бусад хүмүүсийн дур зоргоороо

аашлан халдах явдлаас хамгаалах асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулжээ.

Энэ нь хүний нэр төрийг эрх зүйээр хамгаалах үндсний хэмжээний гол эх сурвалж болоод зогсохгүй "Хүний эрхийн түзээлт тунхгял", "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт"-ын үзэл санаатай нийцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гарээнд засас эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гээж узвл уг эрхээ хамгаалуулсаар шүүхэд гомдол гаргах, бусадын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй", мен зүйлийн 16.17 дахь хэсэгт "Хүний эрх, нэр тэр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндсний аюулгүй байдал, нийгмийн хувь журмыг хангах зорилгоор задруулж үл болох тэр, байгууллага, хувь хүний нууцгүй хуулиар тогтоон хамгаалаха" хэмээжээ.

Мен хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т Монгол Улсын иргэн "Хүний нэр тэр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх" үүрэгтэй заасан байна.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хууль нь хүний нэр тэр, алдар хүндтэй эрх зүйээр хамгаалах үндсний хэмжээний хамгийн гол эх сурвалж болж байна.



<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-2002/, УБ 1998

# Ерөнхийлөгчийн институттэд эрх зүйт ёсны үүднээс хандах нь



МУИС-ийн Хууль зүйн  
сургуулийн докторант  
Ч.Өнөрбаяр

Үдиртгал :

Нэгэн зүйлийг итгэл тэгс хэлж чадах байна. Соёлт хүн төрөлхтэн улсын бүр нэгдэн наягтарч буй өнөөгийн ерөнчдэд эрх чөлөө, тэгш эрх, ёс суртахааныа бамбай хийсэн Эрх зүйт ёс (Rule of law)<sup>1</sup> дэлхий дахинаа өөрийн ялалтыг үргэлжлүүлж байна.

Түүнийг эрхмээн дээдлэх үнэт зүйл гэдгийг бүгдээр хүлээн зөвшөөрөх боллоо.

Тийм ч учраас оюун хуаант хүмүүнлийн бүтээж буй болгосон бүхэн энэ бүгдийг баталгаажуулж, хамгаалах үүрэгтэй.

Ингэж байж гэмээнз бидний оршин буй нийгмийн үндсэн зорилго хангагдах учиртай.

Үндсэн хуульт ёс ба Ерөнхийлөгчийн институт

Эдүгээ үндсэн хуульт ёсиг хууль бол эцсийн бөгөөд дээд хүчинтэй, төр застийн эрх мэдэл ард түмнээс үзэлтэй, застийн үйл ажиллагаагаа хууль, эрхээр хязгаарлагдсан, хууль нь хүний эрхэд үндслэлгэсэн байхыг ойлгодог<sup>2</sup>.

Иймд Үндсэн хууль нь иргэний үндсэн эрхийн бүхий ласуудлыг үүрд мөнхийн болгон баталгаажуулж өгсөн хэм хэмжээнүүдийн орлог, ардчилсан эрх зүйт төрийн сурье зарчмыудын бүрдэл юм. Үүнээс үзүүн төрийн эрх мэдэл хэрэгжүүлэлтийг үндсэн хууль төрийн тогтолцоонд зарчмынх нь хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад хуваарилан тэнцвэржүүлдэг.

Х.Кельзений онолоор төрийн нэгдмэл эрх зүйн дэг журам<sup>3</sup> гэж ойлгож юм болтуний институтууд нь бүрэн эрх, чиг үүргийн хувьд эрх зүйн хэм хэмжээ хийгээд үндсэн хуульт ёсны зарчмуудаар баталгаажиж, хангагдсан байх учиртай. Ерөнхийлөгчийн институт ч энд хамаарна.

Харин Ерөнхийлөгчийн институтын эрх зүйн статусын

шалгуур нь түүнийг сонгох ёсон, парламентаас хэр хамааралтай, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хэрхэн оролцож бүрэн эрхтэй, үйл ажиллагаагаа хэний өмнө хариуцан тайлагнадаг, үйл ажиллагааны эрх зүйн хэлбэрийн хучин төгөлдөр байдал зэрэгрээр тодорхойлгогдог.

Орчин үеийн эрх зүйт ёс бүхий ардчилсан төрийн тогтолцоог хамгийн ерөнхий байдлаар:

1. АНУ-ын Ерөнхийлөгчийн загвар
2. Британийн парламентын (Вестминистр) загвар гэж ангилаад.<sup>4</sup>

Америкийн загвар нь "Check and balance" буюу "Эрх мэдлийг хянан тэнцвэржүүлэх" зарчимд тулгуурладаг<sup>5</sup> бөгөөд хууль тогтоох үйл ажиллагааны цэмийг засгийн газар гүйцэтгэдэг.

Харин парламентын ардчилалд Засгийн газар ба парламентын олонхи аль аль нь ажил хэргийн нэгдлийг бий болгодог. Учир нь энэхүү тогтолцоонд Засгийн газар хийгээд хууль тогтоогийн олонхи нэг нь негөөгүйээр оршиж аргагүй байдаг.

Германчууд 1949 онд АНУ-ын ерөнхийлөгчийн болон Британийн парламентын загварын зөрэг, серег аль аль талын харгалзан өөрийн онцлог бүхий системийг үүсгэжээ.

Энэхүү систем нь парламентын ардчилалда төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг анх удаа авч хэрэглэнээрээ

<sup>1</sup> Англи хэлнээ "Rule of law", Германаар "Rechtsstaat" гэх ойлголтыг "Эрх зүйт ёс" хэмээн буулгав.(Зохижуу)

<sup>2</sup> The New Encyclopedia. Vol. 25. p. 979.

<sup>3</sup> M.D.A.Freeman Introduction to Jurisprudence. Seventh Edition. London., 2001. s 300. H.Kelsen. Pure Theory of Law.(1935). General Theory of Law and State. (1946)

<sup>4</sup> Вольфганг Иегер ХБНГУ-ын парламентт ёс, ардчилал. Шинэ толь.УБ.,1994. №03. 20 дахь тал.

<sup>5</sup> Вольфранг Иегер ХБНГУ-ын парламентт ёс, ардчилал. Шинэ толь.УБ.1994.№3. 20 дахь тал

Британийн сонгодог загвараас ялгагддаг.

Боннын парламентат ёс хэмээн нэршсэн эл системийг орчин үеийн парламентын арчиллын хамгийн шилдэг загвар хэмээн судлаачид тэмдглэсэн нь бий.

Үндсэн хуулийн эрх зүйчид Боннын системийн үүслийг Ваймерийн Бүгд Найрамдах Улс нуран унасантай холбон тайлбарладаг.

Тухайлбал, Фрейбургийн их сургуулийн профессор Вольфганг Йегер “Ваймерийн БНУ нуран унахад ард түмнийг төрийн хэрэгт шүүд татан оролцуулах зарим механизмын байсан, Рейхийн Ерөнхийлэгчийг сонгох шууд сонгууль, Ерөнхийлэгчийн хэт их эрх мэдэл, итгэл нийдвэр алдсан хэмээн Рейхстагаар дамжуулан Засгийн газрыг шууд огцруулах боломжтой эзрг нь нөлөөлсөн” гэжээ.

Дээрхээс иш үндэс болгон ХБНГУ-ын Парламентын зөвлөлдөр дараах онцлог бүхий парламентт ёсны тогтолцоог бий болгосон байна. Үүнд:

- Ард түмний шууд орцлоог хягаарлах; (Гагчхүү төлөөллийн арчилал байх)
- Ард түмнээс шууд сонгогдох төрийн ганц байгууллага нь парламент байх;
- Засгийн газрыг байгуулах журам;
- Канцлерын байр суурийг бэхжүүлэх;

- Гүйцэтгэх танхимиийг татан буулгах “конструктив” зарчим;
- Парламентыг тараах болзлыг хатуу тааж, хязгаарласан;
- Төрийн эрх мэдлүүдийн хоорондын харилцаа, хяналт тэнцлийг тодорхой тогтоосон;
- Х о л б о о н ы Ерөнхийлэгчийн эрх хэмжээг хатуу тогтоосон;
- Намуудын эрх, үргийн нэгдлийг тодорхой заасан зэргийг дурдах болно?

Үндсэн хууль бүхий төр нь төрийн эрх мэдлийг эрх зүйн арга хэрэгслээр хягаарлах ба хянах гэсэн оролдлого юм.<sup>3</sup> Тиймээс Үндсэн хуулийн байгуулалт Холбооны Ерөнхийлэгчийн эрх зүйн статус нь дараах байдлаар журамлагдсан байдаг.

Холбооны Ерөнхийлэгч нь Ваймарын Иргэн улсын Рейхс Ерөнхийлэгч шиг ард түмнээс сонгогдохгүй. Харин Холбооны чуулган хэмээх институуцээс сонгодноно.<sup>4</sup>

Энэ нь парламентын хяналтаас гадуур Ерөнхийлэгчийн институутыг ашиглан улс төрийн явцуу бүлэг төрийн эрхэнд гарах боломжийг хаадаг.

Холбооны чуулган нь Бундестагийн нийт гишүүд, түүнтэй тэнцүү тооны мух улсын төлөөллийн гишүүдээс бүрдсэн онцгой байгууллага агаадгагчхүү Холбооны Ерөнхийлэгчийг сонгох эрх хэмжээтэй.

Чингэснээр Холбооны Ерөнхийлэгч нь хүн амын болон

муж улсын хэн алиных нь ашиг сонирхлын нэгдмэл илрэхийлэл болох мөртөө Бундестаг, Бундесратаас хэн алинаас нь хараат бус институут болно.<sup>5</sup>

Боннын парламентат ёсны бас нэг онцлог шинж нь Ерөнхийлэгчийн институт Засгийн газрыг байгуулахад, ергэн эрх хэмжээтэй оройцдог. Тухайлбал, Холбооны Ерөнхийлэгчийн санал болгосноор Холбооны Канцлерыг Бундестагаас сонгох бөгөөд Засгийн газрын гишүүдийг Ерөнхийлэгч томилдог.<sup>6</sup>

Энэ нь хууль тогтоох байгууллагын улс төрийн сонирхлыг Засгийн газар руу оруулагчай хаяж байх ундуун хуульт ёсны хамгаалал болдог.

Үүний ээрэгээ Канцлерт буюу Засгийн газарт итгэл үзүүлэх тухай асуудлыг хэзэлцэхэд “конструктив” зарчмыг оруулж өгсөн байдал. Уг зарчим ёсоор Канцлерт парламентийн олонхи итэл үзүүлэхгүй бол Ерөнхийлэгч ергэн давшүүлсэн хүчин нэрийг шууд батламжилна. Тийн санал болгод� сонгох асуудлыг дечин найман цагийн дотор шийдэх учиртай.

Шинэ Канцлерыг сонгох хийгээд түүнд, итгэл үзүүлэх асуудлыг шийдэж чадалгүй хугацаа алдсан явдал нь Ерөнхийлэгчид Бундестагийг тараах хууль зүйн үндэслэл болно.<sup>7</sup>

Эл механизм гүйцэтгэх эрх мэдлийг улс төрийн ашиг сонирхлоос харьцангуй бие даасан байх хууль зүйн боломжийг бүрдүүлж, эрх зүйт ёсны “Check and balance” зарчмыг хангадаг.<sup>8</sup>

<sup>1</sup> Вольфганг Йегер ХБНГУ-ын парламентат ёс, арчилал. Шинэ толь. УБ., 1994. №03. 20 дахь тал.

<sup>2</sup> Alfred Katz. Staatsrecht. Heidelberg 1991. S. 157-158.

<sup>3</sup> Дитрих Мано. Эрх зүй, улс төрийн хоорондын харилцаанд Үндсэн хуулийн шүүхийн эзлэх байр суурь. Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын эрх зүйн болон ёс зүйн үндэс. Симпозиум. УБ., 1998. 63 дахь тал.

<sup>4</sup> ХБНГУ-ын Үндсэн хууль. 54 дүгээр зүйл.

<sup>5</sup> О.Машбат Боннын системийн үүсэл. Эрх зүй сэтгүүл. УБ. 2002. № 8-9., 117 дахь тал.

<sup>6</sup> ХБНГУ-ын Үндсэн хуулийн 63, 64 дүгээр зүйл.

<sup>7</sup> Өлзийжайн Парламент. УБ., 2001. 93 дахь тал.

<sup>8</sup> ХБНГУ-д 1972, 1983 онд Үндсэн хуулийн эл механизмын дагуу Бундестагийг тарааж, эзлжит бус сонгуулуулж явуулсан байдал.

**Монгол Улсын  
Ерөнхийлэгчийн институт ба  
Үндсэн хуульт ёс**

Монголчууд сахаан болтол Ерөнхийлэгчтэй байж уззэгүй<sup>1</sup>. Ерөнхийлэгч бол Монгол Улсын төрийн тогтолцоонд цоо шинээр бий болсон албан тушаал<sup>2</sup> хэмээн манай улсын үндсэн хуулийн эрх зүйч эрдэмтэд тэмдэглэсэн нь бий. Гэсэн хэдий ч үндсэн хуульт ёсны онол, арга зүйн үндээс хандвал Монгол Улсад төрийн тэргүүний институт ХХ зууны эхэн үеес үүсэлтэй. Үүний гол нотолгоо бол Хаант Оросод хэвлэгдэж байсан "Дальний восток" сэтгүүлийн 1913 оны дугаарт Богд хааны зарлигаар Үндсэн хуулийн төслийн боловсруулсан тухай мэдээлсэн бегеед уг төслид: Хутагт/Богд хаан/ парламентийн хуралдуулах, хаах, тараах эрхтэй... цолхөгжм олгох эрхтэй, мөн өршөөл үзүүлнэ"<sup>3</sup> гэжээ.

Улаамжар 1921 оны XI сарын эхээр Ардын засгийн газрын хурлаар Богд хаан ба Засгийн газрын хоорондын харилцааны эрх зүйн үндсийн тодорхойлсон "Тангараг дүрэм" хэмээх эрх зүйн актыг баталсан байна.

Эл дүрмийн оршилд: Одоо цаг хэдийгээр Монгол Улсад хэмжээт эрхтэй засаг байгуулсан болгоч эдүгээ хуртал улсын хаан ба Засгийн газрын хоорондын барилдлага, эрх мэдлийг тогтоосон дүрэм хууль гаргаж тэнхлагласангүй.

Үүнээс урагш энэ хэвээр тус улсын хэргийг явуулбаас улсын хаан ба Засгийн газрын

хооронд үл тохиорох явдал гарч, улсын байдал амар угүй болж болзошгүй тул, Монгол Ардын Засгийн газраас хэмжээт ард улсуудын үндсэн хуулийн гол утгыг баримтлан<sup>4</sup> энэхүү дүрмийг тогтоосон байна.

Гэвч энэ бухэн Богд хааныг тэнгэрт хальсны дараагаар үлэхиллэгдаа нь улам бүр идэвхжсэн Зөвлөлт – Коминтернийн нөхөнгөөр тасарсан болой.

Харин 1990. онд батлагдсан "БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль"-ийн "БНМАУ-ын төрийн дээд эрхийг барих ёс" гэсэн нэгдүгээр бүлэгт Монгол Улсын Ерөнхийлэгчийн байгуулалтын шинэр тогтоож, 1992 оны Үндсэн хуулиар төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу бэхжүүлсэн юм.

"Засгийн бүх эрх ард түмний мэдэлд"<sup>5</sup> хэмээх ардчиллын тулгуур зарчим Монгол Улсын Үндсэн хуулиар баталгажээ.

Монголын ард түмэн төрийн ўл хэрэгт шүүд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлгөчийн байгууллагаархаа уламжлан энэхүү эрхээ эзэнэ.

Энэ нь ард түмэн төрийн эрх мэдлийн уг суурвалж болох хувьдаа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлээр дамжуулсан өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал мен. Иймд Үндсэн хуулийн байгуулалт багас төрийн бүхий л институутууд иргэний эрх, эрх чөлөөг хангаж, баталгаажуулах замаар нийгэмд шударга ёсиг

тогтоох үндсэн зорилгыг хангахын тулд гагцуух хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн байгуулалт Ерөнхийлэгчийн институт ямар байр суурь эзлэх, эрх мэдэл хуваарилалтын аль салаа мөчирт хамаарах асуудал эрдэмтэн, судлаачдын дунд маргаантай хэвээр байна.

Тухайлбал, профессор Б.Чимид "...Ерөнхийлэгчийн статусыг гүйцэтгэх эрх мэдлийн чиглэлээр голчлон тодруулах нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд илүү нийцнэ"<sup>6</sup> хэмээн дүгнэсэн бол профессор Н.Лүндэндорж "Төрийн эрх мэдлийн" гурван салаа мөчирин уялдаа, тэнцвэрийг хангахад чиглэгдэн зохион байгуулагдсан Ерөнхийлэгчийн институт нь чухам хаана байршил буй нь тодорхойгүйгээс гадна эрх мэдлийн гурван салбарын жинг дарж тэнцүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зарим зохицуулалт дутуу байгаа нь анзарагдаж байна"<sup>7</sup> гэжээ.

Гэтэл доктор Д.Лүндэнэжанцан "Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоонд төрийн тэргүүн – Ерөнхийлэгчийн институт, засгийн газар, түүний бүтцийн байгууллагууд, орон нутгийн засаг, захирагаа хамруулсан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын нэг онцлог гэж үзэж болно"<sup>8</sup> гэсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлэгчийн институт төрийн эрх мэдлийн аль салаа мөчирт хамаарах эсэх асуудал түүний

<sup>1</sup> Б.Чимид Ерөнхийлэгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. Ерөнхийлэгчийн институтыг боловсронгуй болгох нь. Онол, практикийн бага хурал. УБ., 2003. 17 дахь тал.

<sup>2</sup> Ж.Амарсанаа Ерөнхийлэгчийн бурган эрхийн баталгаа. Ерөнхийлэгчийн институтыг боловсронгуй болгох нь. Онол, практикийн бага хурал. УБ., 2003. 65 дахь тал.

<sup>3</sup> Ч.Өнөрбаяр Монгол Улсын Үндсэн хуулыт ёсны үзэл санаа нэвтэрсэн нь. (1911-1924). УБ., 2005. 72 дахь тал.

<sup>4</sup> УТТА. 11. т-1. ХН-14 б.

<sup>5</sup> Б.Чимид Ерөнхийлэгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. Ерөнхийлэгчийн институтыг боловсронгуй болгох нь. Онол, практикийн бага хурал. УБ., 2003. 34 дахь тал.

<sup>6</sup> Н.Лүндэнэжанцан Төрийн эрхийн сэтгэлэгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002. 304 дахь тал.

<sup>7</sup> Д.Лүндэнэжанцан Монгол улсын дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001. 198 дахь тал.

эрх зүйн статусаар тодорхойлогдох нь маргашигүй үнэн билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн институтын эрх зүйн статус АНУ-ын Ерөнхийлөгчийн болон Боннины парламенттэй ёсны загварын аль алинаас нь эх авсан байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч эрх зүйн статусын хувь:

1/ Түүний бүрэн эрхийг УИХ хүлээн зөвшөөрдөг.

2/ УИХ-д ажлаа хариуцан тайллагнадаг.

3/ Зарлиг ба бусад шийдвэр нь хуульд үндэслэн түүнд нийцсэн байх зарчмытай бөгөөд хэрэв харшилвал УИХ хүчингүй болгох эрхтэй.

4/ Ерөнхийлөгч Ерөнхий сайдар томилж, Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах, Улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах, уччал үзүүлэх, Зэвсэг хүчиний ерөнхий командлагч байх, Шүүхийн ерөнхий зөвлөлөө Улсын дээд шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус томилж, Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроо зургаан жилийн хугацаагар томилдог зэрээрээ парламентын ардчиллын Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй үндэслээд дүйдэг.

Гэтэл УИХ-ас 1999 оны 12 дугаар сарын 24-нд Үндсэн хуульд оруулсан "нэмэлт, өөрчлөлт"-өөр Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцэн

Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэсэн заалтын дээр "Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй 7 хоногийн дотор зөвшилцэх чадаагүй бол УИХ-д өөрөө өргөн мэдүүлнэ" гэсэн 2 дахь хэсэг нэмжжээ.<sup>1</sup>

Энэ нь ног талаас Ерөнхийлөгчийн институт гүйцэтгэх эрх мэдлийн бие даасан байдлыг хангаж чадахгүйд хүрч, негеё талаас парламент дахь улс төрийн ашиг сонирхол Засгийн газар руу хяналтгүйгээр нэвтрэх боломжийг бүрдүүлж байна.

Иймд үг асуудлыг үндсэн хуульт эсны зарчмын нийцүүлэн засварлагч бол Монгол Улсын Үндсэн хуулийн байгуулалт, түүний суурь үнэт зүйлсийг эвдэх аюултай.

Монгол улсын хувь Ерөнхийлөгчийг нийт ард түмнээс сонгодогороо америкийн завартай адил төстэй боловч, энэ нь "Ерөнхийлөгч бол монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэг мөн"<sup>2</sup> гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалаас ундаргатай.

Харин Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хулээн зөвшөөрсөн хуулийн УИХ-ас батлан гаргадаг нь парламентын хяналтгас гадуур дарангуйлаан тогтох нүх сүвийг эрх зүйтээр хаах үндсэн хуулийн механизмыг болдог.

Парламентын ардчиллын нэг онцлог шинж нь хууль тоогочдын олонхи Засгийн газарт итгэл үзүүлээгүй тохиолдолд Ерөнхийлөгч парламентыг тараах хууль зүйн үндэслэлийг тодруулах;

хэрэгжүүлэх боловжгүй гэж нийт гишигүүний гуравны хоёртос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцэн санал болгосноор өөрөө тараах шийдвэр гаргаж болно"<sup>3</sup> гэжээ.

Үүнийг "парламент олон тумийн өмнө нэр нүүрээ барахгүйээр улс төрийн бүүлгийн хийж байгаа манай Үндсэн хуулийн онцлог хошигуулалт" хэмээн зөвлүүлжин тайлбарлаж болох юм. Гэсэн хэдий ч энэ нь парламентын "super" нöхрхол тогтох орон зайд бий болгож, эрх зүйт эсны "Check and balance" зарчмыг харшилдаг.

**Дүгнэлт:** Парламентын ардчилалд Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүргийн амин сунс нь Үндсэн хуулийн байгуулалт дахь улс төрийн намуудын хүчиний харьцаат тэнцвэрхүүлж замаар улс төрийн амьдралын өдөр тутмын ширүүн тэмцлийг намжаахад оршдог. Иймд дараах хэдэн асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн төвшинд шийдвэрлэх саналтай байна.

□ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг байгуулахад оролцох Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг яргатх;

□ Гүйцэтгэх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахын тулд Ерөнхийлөгчийн парламентыг тараах хууль зүйн үндэслэлийг тодруулах;

Ингэснээр Үндсэн хуулийн байгуулалт дахь Ерөнхийлөгчийн үүрэг оролцоо ардчилсан зарчмын дагуу өснөн нэмэгдэх нь дамжигүй ёэ.

<sup>1</sup> Б.Чимид, Ерөнхийлөгчийн байгуулалтын талаархи Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. Ерөнхийлөгчийн институтыг боловсруонгий болгох нь. Онол, практикийн бага хурал. УБ., 2003. 34 дэх тал.

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль. 1992., 30 дугаар зүйлийн 1 дахь заалт

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хууль. 1992., 22 дугаар зүйлийн 2 дахь заалт

# Монгол дахь хууль дээдлэх ёсны толготшил - онгорсон, одоо, ирээдүй

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан Э.Ганболд

## Ойлголт, мөн чанар

Аливаа судлагдахууныг шинжилж авч үзэхдээ түүний уг сурвалж, үүсэл гарлыг бага гэлтгүй ухаж гаргаж ирэх нь түүний мөн чанар, уялдаа холбоог нэн илрүүлэхэд суурь үндэс болох нь олонтай.

Монгол сэтгэлгээний талаасаа ч, уг зүйн талаасаа ч "Хууль дээдлэх ёс" гэсэн томъёолол нь нийгэмд дагаж мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээ мөн зарим талаараа заншлын хэм хэмжээг тухайн хүний нийгэмд эзэлж байгаа байр сууринаас хамаарсан их, бага цар хүрэнд хамаарсан харилцан адилтүй байдлаар илэрдэг. Үр дагавар нь ч бас мэдээж янз бүр.

Хууль нь хүний нийгэмд амьдрахад зайлш-гүй швардлагдах зан үйлийн хэмжээ, хязгаар хамгаалал-тыг бий болгож, зарим талаараад түүний оршин тогтонон үндсан дэвсгэр нехцээн болж өгдөг.

## Түүхэн хөгжил

### Өнөөгийн байдал

Монголчуудын хэм хэмжээ, тухайлбал эрх зүйн хэм хэмжээг бүтээж, ашиглаж ирсэн уламжлал, туршлага нь "Их засаг", "Халх журам", "Их цааз", "Халх дөрвөн /дөрвөд/ ойрадын бичиг", "Талын 21 хууль" зэрэг эх сурвалж-жуудаас харагддаг.

Эдгээр түүхийн сурвалж-

үудыг харахад ихэвчлэн ёс заншлын хэм хэмжээг эрх зүйн хэм хэмжээний төвшинд аваачсан байдаг нь ажиглагддаг. Энэ нь эрх зүйн хамасар буюу соёлыг төлөвшүүлэхэд сэтгэлгээ, ёс заншилд тулгуурласан хэм хэмжээг хүмүүст төрөвшиж тогтоход ойр дөхөм байдаг-тай холбоотой байсан боловшуу гэж бодож байна.

Эрх зүйн ямар хэм хэмжээ тогтоож, хэрэгжүүлж байсан байдлыг хүй нэгдлийн нийгмийг алгасан /эх сурвалж дутмаг байгааг харгалзан үзнэ үү/ тухай үеийн төрийн байдлаар нь аянгилж үзвэл :

### Хаант төрийн үе буюу

#### Феодалийн нийгэм

1. Чингисийн үеийн буюу алтан ургийн хадуудын тогтоож байсан хууль буюу цэргийн дэглэмд тулгуурласан хууль.

Энэ үед хууль тогтоох, хэрэгжүүлэх систем нарийн чанд байсан учраас хуулийг хэрэгжүүлэх явдал тухайн хүний яс маханд шингэсэн ойлголт болсон байсан.

2. Манжийн хууль, дэглэм, шашны хэм хэмжээ нэвчин орж эзэрхийлж байсан үеийн хууль.

Энэ үеийн хууль нь хүний

эрхийг гаргуунд гаргасан ноёд, түшмэд лам хуврагуудыг өвгүүлж энгийн иргэд, зарц хамхлагыг нарыг зөвхөн яллах, эрүүдэх шинжтэй байсан.

Энэ үесэх эхлэн манж, хятадын тогтоосон монголын хуулийг үл ойшоо явдал бий болсон биеед "Монголын хууль гурав хоног" гэсэн чигүүцүүг гарч хууль "тууль болж" авилга, хээл цутгах явдал-д /хээл хахууль өгөх гэсэн утгатай хуучны хэллэг/ монгол улс автаж байсан үе юм.

### Социалист төр буюу эв хамт нийгэм

Энэ үе нь манай улс Манжийн дарангуйллаас гарч Оросын нөлөөнд орсон үесэх эхлнэ. Энэ төрийн үед вөрсдөө сэтгэг боловсруу-лалгүйзэр орсын хуулийг шууд орчуулан хэрэглэж байсан нь эрх зүйг бүтээх үйл ажиллагааг хэлбэр төдий болгосон ба өврийн хөрсөнд нөхцөлдөхгүй хэм хэмжээг гаргаж байсныг өнгөрсөн системийн үеийн төр, нийгмийн төлөөлэгчид зөвшөөрөхгүй байх үндэслэлгүй юм.

Энэ үед иргэд хуулийг ёс төдий мэдэг, мэдсэн ч үзэл бодлоо илрхийлэх байдал хаагдмал байсан учир нийгмийн идэвхи байхгүй, бусдэг аяландаан дагалдах байдал, хүнд сурталд идэгдэж байсан үе байлаа.

### Ардчилсан төр буюу одоогийн нийгэм

Оросын хуулийг шууд орчуулан хуубарлан хэрэглэж байсан үеэс хөдөлж орос "школ" дээрээс багахан үлдсэн монгол сэтгэлгээг нэмж шинэ Үндсэн хууль баталсан нярай ардчиллын үеэс эхэнэ.

Энэ үеэс бусдыг даган дуурдаж өндөр чадвартай болж хүмүүжсэн бид зөвхөн орос улсын хуулийг орчуулан хэрэглэхийн зэрэгцээ дэлхийн олон улс орны хуулийг монгол "фонт"-оор бичих, холион бантан хутгасан зүймэл хууль гаргаж эхалсан ба үнээс буюу 340 гаран /бие даасан/ хуулиас ихэнх нь өөрийн хөрсөнд ургахааргүй "халуун орны даад модны үрслэг" болж байгаа юм.

Хууль батлах үйл ажиллагааг хэт явцуурсан төлөвлөгөөтэйгээр явуулан хуулийн төслийн жагсаалт гаргаж, түүнийхээ дагуу үхрийн бөөр шиг энэ тэндээс олж, түүж,

цуглувуулж түүнийгээ кнопдон / ямар ч үзэл бодлын уралдаан-гүйцээр 1 кноп хасаг булаг нийгэмний үзэмж сонирхлоор дарамтуулсан олонхи кноп дараах / батлах "мода" ч бас энэ үед гэм биш зан болж.

### Дүгнэлт буюу цаашдын хандлагыг чиглүүлэх нь

Сэтгэлгээнд тухайлбал, монгол сэтгэл-гээнд хууль дээдлэх, хууль сахин хэрэгжүүлэх ухамс-рыг бий болгоход цэргийн дарангуйдал, гадаад улсын эзэрхийлэл, түрэмгийлийн үеийн нийгмийн сэтгэл зүйн ялзрал, нёлөө, үзл суртал, түүнчлэн бусдыг хуубарлан дуурдаж зэрэг явдал дорвitoй нёлөө үзүүлэхгүйг дээр хэсэгхэн дурдсан монгол дахь нийгмийн хөгжлийн үйл явцаар товчхон илэрхийлсэн билээ.

Үүнээс үзэхэд хууль гэсэн ойлголтыг хүнийг

дарамталдаг, айлгадаг, сурдуулдаг зүйл гэх үзэхэсээ өөрийн нь хамгаалах орчин, нөхцөл гэсэн ойлголтыг илүүтэйгээр төрүүлж, хуулийг бүтээхдээ олон талын нарийн шинжилгээ судалгааг бүрэн хийж, хууль бол ямар нэгэн техник хэрэгсэл, компьютер-ийн программыг хангамж биш зөвхөн хүн л амьдрал, үйл ажиллагаа буюу зан үйлдээ хэрэглэнэ гэсэн үүднээс хандаж, хууль зүйн шинжлэх ухааны зэрэгцээ сэтгэл зүйн шинжлэх ухааны өнцгөөс адил хэмжээгээр харж ажилласнаараа эрүүл ухамсар – соёл буюу монгол ойлголтоор хууль дээдлэх ёс төлөвшин, бэхжихэд дорви-той нөлөө үзүүлэх юм.



## Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх

Нэгд. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний үндсэн, салшгүй эрх болох тухай, мөн түүний зарим элементийг бур эрт дээр уеэс хүмүүс таныж мэдсэн нь хүний өөрийн эрхэмсэг оршиж, хувь хүн байх шинж чанар, утга учиртай холбоотой юм.

Негээ талаар хүний итгэл унэмшил, узэл бодолтой байх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг эрх, эрх чөлөөг хаях боож байсан дундад зуны уе, хэмжээлшгүй эрхт хаант засаг, диспотизм, фашизм, тоталитаризм зэрэг нэг хүний хэмжээгүй эрхт ёс, нам, хэсэг бүлгийн дараангуйллын эсрэг олон нийтийн зугээс хийсэн тэмцлийн дун үйл байв.

Төвчөрөх хэлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний эзлэх ёстой үндсэн эрх, тэр нь зайлшгүй болохыг дээр дурдсан хэмжээгүй эрхт хаант засаг, фашизм, тоталитаризм зэрэг дараангуйллын дэглэмжийн дураар авирах явдал зарим талаар нөхөлслөн гэж үзэж болно.

Түүхэнд анх удаа 1789 оны Францын Хүний ба Иргэний эрхийн тунхаглалын 11 дүгэр зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийн тунхагласан байна. Зарим эх сурвалжид хүний эрх, эрх чөлөөг Францын хувьсгалас хүн төрөлхтөнд иргэн барьсан бэлзгээн тэмдглэглэсан байdag бөгөөд Францын Үндсэн хуулийн оршил хэсэгт хүний эрхийн тухай заалтууд бий. 1789 оны Францын Хүний ба Иргэний эрхийн тунхаглалын 11 дүгээр заалт нь Францын (1958) Үндсэн хуулийн оршилын нэг хэсгийг бүрдүүлдэг ба үнчд "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний хамгийн үнэт эрх чөлөө юм. Иймээс хүн бур чөлөөтэй ярих, бичих, хэвлэх эрхтэй бөгөөд чингэхдээс энэхүү эрх чөлөөгөө



ХЭҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Д. Ороско

буруугаар ашиглалсан бол тус хуульд завсан тохиолдлуудад хариуцлага хүлээх болно." Тэж заажээ.

Хоёр. Дэлхий нийт болон бус нутгийн хамарсан дайн дахин, зарим улс оронд тогтсон дараангуйлалын улмаас хүний эрх ихээр зөрчигдэж, түүнтэй тэмцэх нь олон улсын асуудал болж энэхүү шаардлагалаг НҮБ байгуулгадсан нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг батлан гаргах урьдчилсан нөхцөл болсон.

Өмнө нь хүний эрхийн төлөөх хөдөлгөөн, тэмцэл зарим улс орон бурийн дотоод амьдралын зөрчилдөөний нэг гол цаг болж ирсн агаад өдгөө ч тийм байна. Энэхүү тэмцлийн явцад 1215 оны 63 зүйл бүхий Английн "Magna charta" буюу "Эрх чөлөөний Харти", 1776 оны Виржиниийн Үндсэн хууль, 1787 оны АНУ-ын Үндсэн Хууль, 1788 оны Францын эрэгтэйчүүдийн эрхийн Тунхаглал, 1789 оны Францын хүний болон иргэний эрхийн тунхаг, 1898 оны Францын Хүний эрхийн Лига, Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (1966) зэрэг чухал

баримт бичгүүд гарч олон оронд тусган юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг 1948 оны 12 дугаар сарын 10-нд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблей-гаас батлан гаргасан нь хүний эрх, эрх чөлөөг олон улсын хэмжээнд бух нийтээр сахин хангах олон улсын эрх зүйл хэм хэмжээний болгон тунхагласан түүхэн үйл явдал байлаа.

Уг тунхаглалын 19 дүгээр зүйлд хүний узэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай "Хүн бур өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа узэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хягаарлан боломжтой арга замаар эрэн сурвалжлах, олж ашиглаж, түгээн дэлгэрүүлэх эрх багтана." гэж тунхаглан заасан юм.

Гурав. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь хүний мен чанар, оршин байгаатай нь холбогдон гарч ирдэг, төрөөс тогтоодогтуй түүнээс ангид оршид, хүний төрөлх буюу санааны эрх гэж ойлгох болно.

Уг эрхийн нийгмийн үзтэй зүйлийн нэг гэж узэл болохын хувьд, хүний төрөлх эрхийн хувьд. Олон улсын гарзэ болон Үндсэн хуулийн эрх зүйл баталгаагаар хангагдад.

Уг эрх нь нийгэмд ил тод байдал, эрүүн саруул орчин, ажил хэрэгч, шүүмжлэлт чанарыг төлөвлөхүүлэх, нийгмийг тогтолцоожуулэх хэрэгсэл мөн бөгөөд иргэний нийтгээ, ардчиллын тулгуур, гол баталгаагаар болно. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь маш эмзэг, байнга хөндөгдөх байdag бөгөөд түүнийг маш зөв, соёлтой хэрэглэх.

хамгаалах учиртай.

ХБНГУ-ын Пассау хотын их сургуулийн хуулийн факультетийн референдр Мориц Лоренц: "Үзл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн "эрхээн зорилго", утга учир бол нийтгэс, хамт олонд мэдээлэл түгээх, үзэл бодол, оюун санааны нөлөө үзүүлж, итгэл үнэмшил, үзэл бодол бий болгоход оршдог. Энэхүү үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь тодорхой процессын явцад хэрэгждэг.

Дарангуйлын дэглэм нийгмийн үзэл бодлыг эзэмшилдээ авсан нөхцөлд дарангуйлын эсрэг тэмцэл ямар ч үр дүнд хүргж чадахгүй гэдгийг энэ гашуун туршлага хотолсон юм. Тийм учраас үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь орчин үед юуны өмнө төрийн аливаа үзэл бодлын дарангуйлын эсрэг чиглэсэн юм. Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан нь застийн газрын талаар гарч буй шумгийнээлийн талаар мэдээлэлтэй байх гэсэн олон нийтийн сонирхлоос дэзгүүр тавсан юм.

Тийм учраас өөрийнх нь үзэл застийн газрын эсрэг чиглэсэн хэдий болочиж хүн бүр түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байх ёстой. Застийн газар нь нийтийн зориулалт бүхий эх сурважлаас мэдээлэл авах, түүний дотор серөг хүчиний бай гадаадын сонин хэвлэл уншиж, мөн гадаадын радио нэвтрүүлэг сонсохыг хориглох эрхгүй. Хэвлэлний эрх чөлөө ба радио, киноны сувгаар мэдээлэл түгээх эрх чөлөө нь эдгээр хэвлэл мэдээллийн хэргэсэл нь застийн газраас хараат буй байж, явдлыг илэрхийлж байгаа юм. Учир нь национал-социализмын үзэл бодлын дарангуйлалт нь юуны өмнө застийн газар сонин хэвлэл, радио, кино эрх мэдэлдээ авсан явдалд тулгуурлаж байсан юм."<sup>1</sup> гэжээ.

**Дөрөв.** Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөө нь хүн өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлой байх, аливаа мэдээллийг эрхийх, олжавах, түгээх, мэдээлэл

хүртэх эзргэргүйт нягт холбоотой, өргөн хүрээтэй ойлголт юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн "эрхээн зорилго", утга учир бол нийтгэс, хамт олонд мэдээлэл түгээх, үзэл бодол, оюун санааны нөлөө үзүүлж, итгэл үнэмшил, үзэл бодол бий болгоход оршдог. Энэхүү үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь тодорхой процессын явцад хэрэгждэг.

Нэг талаас иргэн хүн өөрийн сонирхсан мэдээ, мэдээллийг эрх хийж, олж авах, олж авсан мэдээлэлээ бусад түгээх буюу үзэл бодлоо илэрхийлэх эрх, нөгөө талаас олон нийтийн мэдээлэл хүртэх, хүлээн авах эрх байх шаардлагатай юм.

Хууль үзүүлэх ухааны доктор (Ph.D), дэд профессор Ц.Сарантуяа хүний үндсэн эрхийн тухай "Хүн төрөлхтний тухайн сурвалжаас үүдэн дүгнэхэд иргэн хүний эрх чөлөөг дөвлилгөх, төрийн эрх мэдлийг хязгарагчад чиглэсэн" тал нь нилээд түлхүү анхаарах ёстой элемент байдаг гэдэг нь нотлогдож буй юм. Тухайлбал, үзэл бодлоо өөрийн итгэл үнэмшилээр илэрхийлэх боломжийг үндсэн эрхээр баталгаажуулж байгаа бөгөөд тэр нь тухайн үед нöөрхж буй нийгмийн болон улс төрийн үзэл бодлоос ялгавайт байсан ч үг эрхийг здлэх боломжоор хүн хянагдах ёстой юм.

Үндсэн эрх нь хүнийг төрөс хамгаалах шинжтэй эрхүүд болохын хувьд дарангуйлын төрд байх боломжийг буутийн төрийн оршин тогтохнаа чадварыг бууруулдаг.<sup>2</sup> гэж үзжээ.

**Тав.** Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг өнөө үед Олон Улсын хэмжээнд Олон улсын Пакт, Гэрээ, Конвенцийн хэм хэмжээгээр (мен бус нутгийн хэмжээнд), дотооддоо тухайн улсын Үндсэн хуулиар эрх зүйн хувьд баталгаажуулж иржээ. Тухайлбал, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948). Иргэний болон Улс төрийн

эрхийн тухай олон улсын Пакт (1966). Эмзгайччудийн улс төрийн эрхийн тухай Нью-Йоркийн гэрээ (1953). Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц (1950). Хүний эрхийн тухай Америкийн Конвенц (1969). Хүний эрхийн тухай Африкийн Конвенц. АНУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлт, Финландын улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл, Герман улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйл, Бельги улсын Үндсэн хуулийн 14, 18 дугаар зүйл, Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16, Дани улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйл, Голландын улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйл, Итали улсын Үндсэн хуулийн 21 дугаар зүйл. Тухайлбал, Финландын улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд "Финландин иргэн бүр үзэг чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, мөн хэзин ч урьдчилсан шалгалт, хяналтгүйгээр бичгээр болон зүргээр илэрхийлсэн материалыг хэвлүүлж нийтгүүлэх эрхтэй"; Бельги улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд "Хувь хүнд бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх олонгоно.", 18 дугаар зүйлд "Хэвлэл бол эрх чөлөөтэй, түүний хянан цагдах үзэгдэл байж болохгүй"; Люксембургийн Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлд "Бүх зүйлд уг хэлэх болон хэвлэлийн эрх чөлөө баталгаажсан болно...хэвлэлийн хяналтыг хэзээ ч нэвтрүүлэхгүй байж болно." Гэж тус тус заажээ.

**Зургаа.** Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйд Монгол улсын иргэний баталгаатай эзлэх үндсэн эрхүүдийг засан байдал. Уг зүйлийн 16 дахь хэсэгт "Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооноо.", 17 дахь хэсэгт "Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохиц нууцад хамааврахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Хүний эрх, нэр төр, алдарт хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж ул болох төр,

<sup>1</sup> Мориц Лоренц, "ХБНГУ-ын Үндсэн Хуулийн 5.1.1.1 дэх заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийт ардчилал даа пролетариатын чухал элемент хамзэн үзэх нь", "Эрэгцүүлэлт" 2000. ҮА сар № 7. 105 дахь талд.

<sup>2</sup> Хууль үзүүлэх ухааны доктор, дэд профессор Ц.Сарантуяа "Эрх зүй" сэргүүл. УБ., 1/2000 он, 23 дахь талд.

байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэж заажэл.

Я.Цэвэлзийн монгол хэлний төвч тайбарт толь бичигт "итгал" гэдэг уг нь итгэх уйлийн нэр, бат найдалгаа, сэкигүй үнэмшилсэн санаа, харин "үнэмшик" гэдэг уг нь үнэн гэж итгэмжилж, "үзэл" гэдэг уг нь санааны шийдвэр, санаал болод, "бодол" гэдэг нь хүний ухаандаа сэтгэх, эргэцүүлэх гэсэн утгатайгээ бичжээ. Тэгэхээр "Итгал үнэмшил" гэдэг нь ямар нэгэн комианд итгэж, нийдэж, үнэмшик явахын нэр, харин "Үзэл бодол" гэдэг нь аливаа зүйлэх талаарх санаал болод, тухайн зүйлэх талаар бодх, сэтгэх, эргэцүүлэх, оюун ухааны "дүгнэлт", "шийдвэр" гаргахын нэр ажээ.

"Итгал үнэмшил", "үзэл бодол" гэсэн энэ хоёр ойлголт ялгавтай ч харицлан няйт уялдаа холбоотой, нэгийн нь негеөөгэв нь саглаж ойлгох аргагүй. Хүний иоун санааны эрхийг дотор нь итгал үнэмшилтий байх, үзэл бодлой байх эрх гэж, харин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглалан хийх эрх бас териин байгууллага, албан тушаалтанд өргөдөл, голмодлоо гаргах шийдвэрлүүлэх эрх, нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, одон нийтийн бусад байгууллага байгуулах, эвлэлдэн нэдэх эрх гэх эзргээр ангилан үзэл болох юм.

Итгал үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй няйт холбоотой, салшгүй нэг эрх бол мэдээллийн эрх юм. Мэдээллийн эрхийг дотор нь мэдээлэл хийх, мэдээлэл олж авах, мэдээлэл түгээх буюу дамжуулах эрх, мэдээлэл хүртэх буюу хүлээн авах эрх (The Right to know - "мэдээлэх" гэж ангилж болно).

Хүний итгэл үнэмшил, үзэл бодол нь тухайн хүний хувийн хүмүүжил, өртөнцийг үзэх үзэлтэй холбоотой, хүний итгэл үнэмшил бүрэлдэн тогтох негеэ талаараа

өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо бусад илэрхийлэх явдал нь хүний амьдралын туршил, тасралтууд үргэлжлэх уйл явц юм. Хүний итгэл үнэмшил хэрхэн бүрэлдэн тогтох нь хувь хүний хүмүүжил, түүнийг бүрдүүлэхэд нөлөөлсөн ахуй амьдралын орчин, ушиж судалсан ном бүтээл, дуулж сонссон уг, наиз нөхцөл, хамт олон, сурсан сургууль, эрхэлж буй ажил, албан тушаал, мэргэжил, болосрол зэрэгэс шалтгаалдаг.

Иргэн хүн улс териин аль нам, эвслийг дэмжих, ямар нам, эвслийг дэмжихгүй байх, дэмжсэн улс териин хүчиний үйл ажиллагаанд оролцох, нам, эвслийг тишигнээр эзлэх, төрөөс явуулж байгаа будоого, үйл ажиллагааг дэмжихгүй байх, шүүмжлэх зэрэгч хүний итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудал юм.

Хүний үзэл бодроор нь ялгарварлан гадуурхах, үзэл бодлынх нь төлөө шүүх, хорх, тамлах, мerdeх, хариуцлага хүзлэлгэх явдал бол хүний итгэл үнэмшилтий байх эрхэд хэлдэж буй хөрөн болно.

Хүн өөр төгөвшин тогтолцоон итгэл үнэмшил, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд илэрхийлэх ундсэн аргууд бол уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглалан хийх явдал бөгөөд өөр ямар ч хөлбөрзэр илэрхийлэх эрхтэй. Иргэдийн уг эзлэх эрхийг хаах боох, хэвлэн нийтлэх эрх буюу хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах, цэнээр тогтоох, жагсаал, цуглалан хийх эрхийг хориглох нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй хэрэг юм.

**Долоо.** Хууль зүйн ухааны доктор, профессор Г.Совд: "Монгол улсын үндсэн хуулиар баталгаажуулсан эргийг шүүхийн үйл ажиллагаанд шүүд авч хэрэглэх болно гэсэн уг юм. Тэгээл Үндсэн эрхийг нэг болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь энэхүү өөрөө хэрэгжих (self executing) шинж чанарыг агуулж Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажж санаараа Үндсэн хуулиас бусад хуульд дээд зарчим, хэм хэмжээ болж мөрдөгдөх учиртай.

Эдэлдэг эрх, иргэд хамтарч хэрэгжүүлдэг эрх гэж дотор нь гурав ангилан үзэж болно." гэжээ.

Үүнд хувь хүнд дангааранд нь эзэмшигддэг эрх гэдэгт: итгал үнэмшилтэй байх, үзэл бодлолтой байх эрх, хувь хүнд дангаараа болон бусадтай хамтарч эдэлдэг эрх гэдэгт: уг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, териин байгууллага, албан тушаалтанд өргөдөл, голмодлоо гаргах шийдвэрлүүлэх эрх, иргэд хамтарч хэрэгжүүлдэг эрх гэдэгт: тайван жагсаал, цуглалан хийх, нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх хамаарч байна.

**Найм.** Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь шүүд хэргэхгүй шинж чанартай эрх юм. Өөрөөр хэлбэл: мөрдлөг болгохуүц тов тодорхой "заалт" гэсэн уг. Энэхүү "өөрөө хэрэгждэг" чанар нь хүний эрхийг хангахын тулд хууль тогтоогочоос заавам хэм хэмжээ тогтоосон акт батлан гаргах шаардлагатай гэсэн утгатай бөгөөд өөрөө хэлбэл: шүүгчид хүний баталгаажуулсан эрхийг шүүхийн үйл ажиллагаанд шүүд авч хэрэглэх болно гэсэн уг юм. Тэгээл Үндсэн эрхийг нэг болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Иргэдийн уг эзлэх эрхийг хаах боох, хэвлэн нийтлэх эрх буюу хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах, цэнээр тогтоох, жагсаал, цуглалан хийх эрхийг хориглох нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй хэрэг юм.

\* \* \*

<sup>1</sup> Г.Совд "Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх" (харьцуулсан эрх зүй)  
УБ., 1999 он, 138 дахь талд.

## Татварын хүчин тогтоомжийг хэрэгжүүлэх явцаа анхаарах зарим асуудал

Монгол оронд эрт дээр уеэс татварын харицаа үүсэн бил болж, татвар төлөх эрх зүйн ухамсар ёне эртний түүхтэй ч эрх зүйт төр төлөвшин бүрэлдэх явцад төр иргэнтэйгээ ямагт харицаан хамааралтайн язгуур ашиг сонирхол нь терийн татвар төлөх харилцаагаар илэрч байдал. Тийм ч уираас Англичидууд “терөх нь үнэн”, “үхэх нь үнэн”, “татвар төлөх нь үнэн” гэсэн 3 үзүүний зарчмыг хошигнон тодорхойлсон байдал.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн 3-т зааснаар “Монгол улсын иргэн шударга, хунгын ёсны эрхэмлэн хуулиар ногдуулсан албан татварыг төлөх үргийг ёсчлон биелүүлнэ” гэжээ. Монгол улсын урьд өмнөх Үндсэн хуулийд татвар төлөх үргийг иргэний үндсэн үүргээ болгон хуульчлаагүй бөгөөд гацаанд эн зваалт нь өмчийн болон албан татварын хөрицаанд ойт байгаагүй зарчмын шина зваалт ба Монгол улсад татварын хууль тогтоомжид шинэчтэл хийхдэд чухал ач холбогдол бүхий зваалт болсон юм.

АНУ-ын эрх зүйд "хариуцагчийн хариу нийтлэхийг хүчээр тулгах эрх хохирогчид байхгүй" гэсэн зарчим үйлчилдэг.

#### Хязгаарлалт

"Үндсэн эрх чөлөөг баталгаажуулна гэдэг нь хэмжээ хязгааргүй эрх чөлөөг эдлүүлнэ гэсэн үг биш"<sup>2</sup> Аливаа эрх чөлөө бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагдаг нь ардчиллын нийтгэг хууль.

"Үндсэн эрхийн хязгаарлалт нь үндсэн хуулийн бусад харилцан шүтээлэс бүхий хэм хэмжээнээс урган гардаг.

Үндсэн эрхийн өөр хоорондын ба тэдгээрийн үндсэн хуульт байгууламжийн хоорондын харилцан шүтээлээнээс бий болж буй үндсэн эрхүүдийн харилцан холбоо ба өрсөлдөөнөвөс тэдгээрийн тэнциржүүлж, хязгарагзагийг нь зөв тогтоох, улувтар өөр хоорондоо зөрчилдэж буй эрх чөлөө, эрхүүдийг хошигуулах үргэлтэй урган гардаг."<sup>3</sup>

#### Гэхдээ энэ хязгаарлалт нь

тодорхой үзэл бодлын эсрэг чиглэсэн бус, харин эрх зүйн тодорхой үнэлээмжийн эсрэг, ялангуяа ардчилалт гүйцээд үндсэн хуульт ёсны үндсэн зарчмын эсрэг чиглэсэн тохиолдолд хэрэглэгдэг.

Тодруулбал, "эй ёсны хууль хэдийгээр уг үсгийн хувьд хязгаарлаж байгаа мэт болчвүүн чанартсаа эрх чөлөөт, ардчилсан тэр дэх үндсэн эрхийн ач холбогдуулж нэмэгдүүлж, тэдгээрийн хязгаарлалт буй шинж чанараараа өөрийнхөө үйлчилгээг мөн хязгаарлаж байгаа"<sup>4</sup> хэмээн ойлгодог.

Энэ хязгаарлалт нь агуулгаар дамжин илэрдэг.

Тухайлбал, садар замууныг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах нь өвсөр үеийнхийн хөгжлийн мугаар нөлөөлж болзошгүй учраас улс орон бүрхязгаарлалт тогтоодог.

Мөн үндэсний аюулгүй байдал, хувь хүний нууц болон бусад зарим ашиг сонирхлын үүднээс мэдээллийн чөлөөт ургаслыг олон улсын эрх зүйн дагуу хязгаарлалт болдог.<sup>5</sup>

Гэхдээ хязгаарлалт нь тодорхой байх шаардлагатай. Хэт өрөнхийн хорилгох заалтад нь бусад эрх чөлөөний үзүүлэлж хийгээд зарчмын харшилж болох аюултай байдал.

V. Дээрхээс үзэхэд олон нийтийн хэвлэлт мэдээлэл нь энх тайвныг сурталдан хамгалагчийн үүрэг биелүүлэх тедийгүй тэр хийгээд түүний албан тушаалтнуудын үйл ажиллагааг

хянадаг ард түмний хоточ нохой байж, тэр ба ард түмэн хөөрүүн хооронд олон нийтийн хэлэлцүүлийг өрнүүлэх индрийн үүргэг гүйцэтгэн, илүү боловсруонгийн бодлого боловсруулахад анхаарах замаар ардчиллыг дархлаажуулах чиг үүргийг амжилттай гүйцэтгэдэг институт.

Энэ чиг Үүргээ хэргжүүлэхийн тулд тэр хийгээд бусад улс төрийн нам, бизнесийн бүдаглалээх хэрээт бусад бий болч, олон эшт үзүйг дэмжих, мэдээллийн чөлөөт байдлын зарчмыг баталгаажуулж, сэтгүүлчийг эрх зүйн арга хэрэгслээр хамгаалах нь ардчилсан эрх зүйт төрийн үүргэг учраас эдгээр зарчмытай уялдуулан хууль тогтоомжийг боловсруонгий болгож, хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дархлаажуулах нь манай улсын хуулийн шинжлэх ухааны тулгамдсан асуудал мөн.



<sup>1</sup> К.Осакве Харьцуулсан эрх зүй судлал. Ерөнхий ба тусгай анги. Бүдүүвч. УБ., 2005. 236 дахь тал

<sup>2</sup> М.Лоренц ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1.1 дахь заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плурализмын чухал элемент хэмээн үзэх нь. Эргэцүүлэл. № 4. УБ., 2000. 107 дахь тал.

<sup>3</sup> М.Лоренц ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1.1 дахь заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плурализмын чухал элемент хэмээн үзэх нь. Эргэцүүлэл. № 4. УБ., 2000. 107 дахь тал.

<sup>4</sup> М.Лоренц ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1.1 дахь заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плурализмын чухал элемент хэмээн үзэх нь. Эргэцүүлэл. № 4. УБ., 2000. 107 дахь тал

<sup>5</sup> Хүний эрхийн европын шүүх. 1998.6.9. 22678/93

# Хорих ял эдлүүлэх зарим тулгамдсан асуудал

ҮЕПГ-ын Ял эдлүүлэх ёжиллагаанд хяналт тавих холтсийн хяналтын прокурор Ц.Менхбат

- 2002 онд Улсын их хурлаас Эрүүгийн байцаан шийтгэх багц хувь тогтоомжийн шинэчлэн баталж мөрдүүлснээс хойш 3 жил орчим хугацаа енгэрлэв.

Энэ хугацаанд эдгээр хуулиуд, тухайлбал: хорих ял эдлүүлэхтэй холбоотой хуулийн зүйл ани, заалтын практик хэрэгжилт, түүний явц, амьдралд нийцэж буй байдал, хуулийн хийдэгдэл, зөвчилдөнийн талаараа цаашид анхаарах тулгамдсан асуудал багажуүг үүссүү хүрүүлгэжсан байна.

- Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.11 дахь хэсэгт "Шүүх нь хорих ял шийтгүүлсэн ялтын хорих яланы заримын гянданд эдлүүлэхийн тогтоог болох"-ыг хуулиасын боловч гянданийн дэглэмийг, тухайлбал: чанга аль нь болохыг заагаагүй орхигдуулсан байна.

Хуульд нэгэнт тодорхой заагийн болохуу шүүхээс хорих ял шийтгүүлсан ялтын гянданд ял эдлүүлэхэд дэглэмийн талаар шийтгэх тогтоод тусгагдагтүй байна.

Шүүхийн шийдвэргүйцэтгэх тухай хуулийн 109 дүгээр зүйлд гянданийн жирийн ба чанга дэглэмтэй ялтын бусадтай хийх уулзат, захидал явуулж тоо хэмжээ, хөөрбонд янгааг зааж өгөн ч шүүхийн шийтгэх тогтоод ялтын ял эдлэх дэглэмийн заагаагүй чураас практикт хэрэгжих боломжгүй юм.

Хууль хижнэнэ угтаараа биелгэдэхгүй байх нэг шалтгаан нь манай оронд хуулийн хэрэгжүүлэх нийтийн эдийн засгийн нэхцэл бурдзэгүй байхад эндээ хөгжсөн гадаад оруундын хурам, зааврыг хуулиарблан хуульчлан мөрдүүлж байгаатай холбоотой байна. Жишиээ нь: Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих ангид тус тус ял эдлэж естийн насанд... нь болон хүрээгүй, эмгэгтийн дүйдэй нэг хорих ангид бөөгнөрүүлэн хөрьж, тэдгээрийн зөвхөн амьдрах байраар нь тусгаарлах, бусадтай уулзах тоонд нь хягаар тавихын төгрөгийн тедигийн дэглэмийн яландаа илрэв байна.

Гянданд ял эдлэх эмзгэйчүйд нь эрэгтэйчүүдийн хорих байртай зэрэгдээ ял эдлэж байгаа нь байж болшгүй зүйл юм.

Энэ нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, эдийн засгийн нэхцэл бий болгоо тохиолдолд хуулийн холбогдох заалтыг мөрдэж эдлэх хугацааг хойшлуулах буюу түдгэлзүүлэх хэрэгтэй харуулж байна.

Гянданийн ялтынг өдөрт 1 цагаас доошгүй хугацаатай гадаадын талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 109 дүгээр зүйлд зассан шаардлагын бүрэн хэрэгжэгүй, хэрэгжүүлэх нэхцэлд ч аяла байна. Энэ нэхцэлд гянданийн ялтын өрөө багайгийн гэрлийг илүүтэй тусгас болон байнгын агааржуулалттай байлагх нь ур дүнтэй юм.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдлэж байгаа ялтын хугацаанаас нь эмне тэнсэн суулт болоз шаардлагын нэг нь гэмт хэрэг үйлдэсний улмаас бусадд учруулсан хохирлыг нэхэн төлсөн байх явдал юм.

Өнөөгийн байдлаар хорих ангиуд нь ажлын фронтод дутмаг ба албан бус эх сурвалжас ялтын өөрөө 50-60 хувь нь ямар нэг ажил хийдэг байна.

Хорих ялтын хөдөлмерийн орлогтоос бусдад учруулсан хохирлыг нэхэн төлсөн нь дунджаар 4 хувийн эзлэж байгаа нь тун бага байна.

2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шүүхээр ял шийтгүүсэн ялтын хугацаанаас эмне тэнсэн суулгасан байдлыг судалж узэхэд үндсэндээ ялтын ар гэрийнхэн хохирлыг барагдуулсан байна.

Хуульд зааснаар ялтын өөрийн биеср хөдөлмөрлөж бусдад учруулсан хохирлыг нэхэн төлөх шаардлагын одоогийн нэхцэлд биелгэдэхгүй байгааг анхаарах ёстой.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлийн 332.2 дахь хэсэгт "Онцхүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэг удаа дараа шийтгэгдсэн,

туунчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцгэсэн этгээдийн талаар гарсан төгөл болеүүлэх явдлыг хойшлуулж болохгүй" гэж зассан атал мөн хуулийн 333 дугаар зүйлийн 333.3 дахь хэсэгт ял эдлэж байгаа этгээд зөвхөн бие эрхтэндээс санаатай гэмтээ учруулнаас бусад тохиолдолд өвчин учир хугацаанаас эмне ял эдлэхээс чөлөөлж болохыг зассан нь логикин хувь авчандагүй, хуулийн хийдэгдээл бий болгосон байна.

Тухайлбал: Ял эдлэхэд саад болох хүнд өвчинөөр өвчилсөн онц аюултай гэмт хэрэгтнэйн өвчиний учир ял хойшлуулж болохгүй гэж хуулиар хаалт хийсэн хэрнэ ялас бүр мөсөн чөлөөлж тухай боломж нь наалттай байна.

Жишиээ нь: Хуулийн энэ цоорхой ашиглан хорих нэгдсэн эмнэлгээг гэхэд 2004 онд хөвтэж эмчлүүлсэн ялтын хорих ялтын нэг ч удаа хойшлуулж болгүй (учир нь хуулиар боломжгүй) атал 24 ялтыг (үүнээс 9 нь онц хүнд гэмт хэрэг үйлдсэн байна) ялас бүрмэсэн өвчиний учир чөлөөлсөн байна..

Цаашид дээр дурдсан зарим тулгамдсан асуудлыг шүүхийн шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээг даруй хэрэгжүүлэх, тухайлбал: Хуулийн зүйл, ани, заалтын хоорондын логик үзлэда холбоог сайжруулах, бодит амьдралд нийцүүлэх, хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн найрууллыг сайтар Боловсруулж хууль тогтоо дээд байгууллагас эхэлжүүлэх, онол практикийн шүтэлцээг хангах, эрдэмтэн мэргэдийн судалгахаас бүтээлийг өргөнөөр ашиглах зэрэг олон аргыг хэрэглэх нь ур дүнгээ өгөх нь дамжигүй.

\* \* \*

# Шилжилтийн үеийн Монгол Улс дахь гэмт хэргийн чиг хандлага

ХЭҮТ-ийн Криминологийн судалгааний секторын эрхлэгч, доктор, профессор Д.Зүмбэрэлхам,  
эрдэм шинжилгээний ажилтан, магистр Ц.Одгэрэл нар 2005 оны 8 дугаар сарын 7-11-нд  
АНУ-д зохион байгуулагдан Элхийн криминологичдын 14 дэх  
конгрест хэлэлцүүлсэн илтгэл

Монгол орон хүйтэн дайны үед дэлхийн социалист системийн оруунудын бүрэлдэхүүнд багтаж олон жилийн туршид гэмт хэрэгтэй тэмцэх марксист онолыг удирдлагыг болгож ирсэн билээ.

Тэр үед нийгмийн сэтгэлгээ бүхэлдээ коммунизмын үзэл сурталд хүчтэй автсан байсан бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх ўйл ажиллагаанд ч марксист-ленинист үзэл дангаар нөхцөл бусад үзэл ургалдуудыг үгүйсгэн хориглодог байлаа.

Уг нийэмд ёс суртахуны гажуудал, өмч хөрөнгийн шуналгаас ангижирч коммунизмын үзэл сурталд бүрэн дүүрэн итгэсэн хүмүүс амьдрах ёстой учраас гэмт хэргийн нөхцөл, шалтгаан социалист нийгмийг байхгүй гэсэн номполыг баримталж тухайн үед үйлдэгдэж байсан гэмт хэргийн шалтгааны өнгөрөн нийгмийн формациас үлдэж хоцорсон муу зууршил, капиталист системийн серег нөлөөлөлтэй холбон тайлбарладж байв.

Энэ шалтгаанууд удахгүй арилж дэлхийн бүх улсын коммунизмын замд орно, өнгөрсөн нийгмийн үлдэгдлийг даван туулж түүнчээс уламжлалтадаа муу зууршил хүний охваанаас арилна, тэр үед хүмүүс гэмт хэрэг үйлдэхээс болино гэсэн хийсвэр хэтийн прогнозд үндэслэсэн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг төрөөс боловсруулж хэрэгжүүлдэг байсан юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх тэрхүү бодлогын хүрээнд хүмүүсийн хувийн өмчийн ашиг сонирхлыг дарангуйлан сааруулах, төрийн буюу социалист хэмээн нэрлэдэг байсан өмчийг өөрийн өмч гэж үзж хандак хандлагын нийгмийн гишүүдэд хуушийн дарангуйлал дор албанад төлөвшүүлэхэд гол

анхаарлаа хандуулдаг байсан юм. Тухайлбал, манай улсын социализмын үеийн Эрүүгийн хууль хувийн өмчийг хулгайллах гэмт хэрэгт хүлээлгэх харцууллага харьцаандыг бага байж социалист өмчийн эсрэг үйлдсэн онц хүнд гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулдаг байв.

Мөн коммунизмын үзэл сурталд нийцэгжүү гэж үзсэн хувийн өмчийг хэрэгт тооцсон хэмжээн эрүүгийн хуульд олон байнаас 1930-аад оны үед олон хүн хилс хэрэгт шийтгэдсэн бөгөөд үүний шалган цагаатах ажил суулын 10-аад жил үргэлжилж байна.

Ийнхүү тухайн үеийн гэмт хэрэгтэй тэмцэх болгодог улс тэр, эдийн засгийн хатуу байр суурь хүчтэй нөлөө үзүүлж байв. Энэ бол ганц манай улсын биш, хүчин социалист системийн хэмжээний гажуудал байсан юм.

Хэдийгээр манай улсад гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалсаар судалгааны байгууллагыг ажилласаа байсан боловч судалгаандаа үндэслэн гэмт явдлын шалтгаан, нөхцлийг тухайн нийгмийн гажуудал, түүний үр дагавартай холбож зориглон гаргаж тавих боломж байгаагүй.

Ингэх нь коммунизмын үзэл номполд ноцтой харшинаа гэдгийг судлаачид тооцож бүтээл болон судалгааны үр дүнгийн талаархи танилцуулгадаа тухайн нийгмийг шүүмжлэхээс зайлсхийдэг байв.

Үүний уршгаар Монгол оронд Криминологийн шинжлэх ухааны үзүүлэлтэй талаархи танилцуулгадаа тухайн нийгмийг шүүмжлэхээс зайлсхийдэг байсан.

Нь гэмт явдлын мөн чанарыг бодитойгоор таньж мэдэх, түүнийг нийгмийн хүчин зүйлүүдтэй холбож судлахад саад болсон юм.

1990-ээд оноос хүйтэн дайны үе шүвтэрч, социалист систем задран үнаж, энэ системд байсан оруундад улс тэр, эдийн засаг, нийгмийн бүх салбарт эрэгтэйн чанартай өөрчлөлт гарсан ба манай орощд ачдирсан хөдөлгөөн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ.

Үүний рүү дунд Монгол улс ардилсан хөгжлийн замд орж суулын 15 жилийн турш шилжилтийн үеийн туулж байна. Энэ хугацаанд тус оронд нийгмийн харилцаа, түүний эрх зүйн хошигуулалт, хүмүүсийн хүснэгтэй хөгжлийн хөдөлгөөн үзүүлж байв. Чөлөөт зах зээлийн хөгжлийг гээд олон зүйл шинэлэгдээж өөрчлөгддээ.

Шилжилтийн эхний жилүүдэд хүмүүс энэ олон талын өөрчлөлтэд өочирдэн барьц алдах нь их байсан бол суулын жилүүдэд дасан зохицох нь давамжлах хандлагатай боллоо.

Гэхдээ дасан зохицож байгаа хандлагыг криминологийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл тэр бүр нааштад зөргөг гэж хэлэхэзргүй зарим дүр зураг ажилгадж байна.

Социализмын үед хүн бур хувийн өмч хөрөнгөгүй, хийсэн хөдөлмөрийнхөө хөлсөөр аж амьдралаа залгуулан амьдарч байсан.

Улс орон зах зээлийн эдийн засагт шилжик, төрийн өмч хувьчлагдах үйл ажиллагаагаа явагдсан ба түүний зарим серег үзэгдлүүд дагалдах болов.

Юуны өмнө зохион байгуулалттайгаар бүх нийтээр хөдөлмөр эрхэлдэг албадлагын

тогтолцоо байхгүй болсноор ажилгүйдэл үүсч энэ нь хөдөлмөр эрхлэх наасны хүмүүсийн дотор тодорхой хувийг эзлэх болов.

Мал аж ахуйн хамтрап тарснаас тэр салбарт анхаарал суларч, зохион байгуулалтад шүтэж ажилладаг байсан хамтралын малчдын зарим эзслэг бие даан ажиллах чадвар дутаж цаг уурьн барьшээд автан ядуурч хот суурин газар барагдан хотууд дахь ажилгүйчүүд, ядуучуудын тоогопч онэмлээ.

Энэ нэхцэл байдалтай холбоотойоор хулгай, дээрэм, залиплан мэхлийн зэрэг гэмт хэргүүдийн тоо нэмэгдэв. Эдгэрээгээ хүрдэх буй хүмүүсийн дийлэнх нь боловсрол, хөрөнгө орлогын байдлаараа нийтгийн дундаас доош давхрагад хамаарч байгаа юм.

Үүний нёгөө талд үндэсний баячууд буй болох уйл явц эрчимтэй явагдаж хөрөнгөлж хүмүүсийн тоо нэмэгдэж байна.

Үндэсний хувьчилалт ихээхэн нелөө үзүүлж байгаа юм. Төрийн өмчийг хамд төсөр үнэр төндөрт залыг мэх зэрэглээн эзэмшилдээс авахын тулд бүлэглэж усгэн хууль бусаар өрсөлдөх, албан тушаалтын авилгандын зэрэг байж болох бүх бөхирьгыг хэрэглэж байгаа болочи үүнийг илрүүлж шийтгэх, таслан зогсох талаар хууль сахиулах байгууллагудад анхаарал төдийгүй хандуулажийг байна. Энэ нь бизнес улс төрийн бүлэглэл үүсч, хууль сахиулах байгууллагуудад нөлөөгөө тогтоосонд холбоотой.

Сүүлийн жидүүдийн улс төрийн сонгуульд бизнесийн хүрээндээний орложоо нь элбог болж, нэр дэвшигчийг дэмжин санхүүжүүлэх сонирхолтой хөрөнгөлөг хүмүүс илт олширч байна.

Гэвч албан ёсны гэмт хэргийн статистик албан тушаал, аавилгын гэмт хэргийн тоо есвэхүй, нийт гэмт хэргийн дотор бараг хамгийн бага хувьтай хөвзэр байгаа нь бодит байдалд нийцүүхийг байгаа юм.

Ийнхүү "цагаан захтны" хүрээндийн гэмт хэргийн нэхцэл байдал хяналтнаас гарч, нарийн сохион байгуулалт, сүлжээтэй болж

байна.

Мөнгө угаах гэмт хэрэг одоогоор манай улсад бүртгэгдээгүй боловч энэ нь уг гэмт хэрэг отт үйлдэгдэггүй гасан уг биш юм. Энэ нь Монголын шинэ хөрөнгөтүүдийн нийтлэг дур зураг хараахан биш болочи энэ үзэгдэл анхаарал татах хамжээнд хүрээд байгаа юм.

Монгол Улс газар зүйн хувьд Орос, Хятад хоёр угтавай хиллэн дунд нь оршдог бөгөөд эдгэр орны хөрөнгө оруулалт манай улсын эдийн засагт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэгдэг юм.

Эдгэрээ том гүрнүүдийн бизнес эрхлэгчид Монголд өргөн хэмжээндийн үйл ажиллагаа явуулдаг боловч одоогоор зохион байгуулалтад үндэстэн дамнансаан гэмт булгзлэл илрөч бүртгэгдээгүй байгаа юм.

Харин сүүлийн жилүүдэд анхаарал татах байгаа нэг төрлийн гэмт хэрэг бол хүн худалдаалах явдал юм. Монголоос царайдалаа заплуу эмзгийчүүдийг БНХАУ болон зүнгийн азийн зарим орнуудад зуучлан гаргаха, тэндэхийн хүмүүстэй гэртуулзлах зэрэг ажлыг дагнан эрхэлдэг зохион байгуулалтад бүлгүүдэд цөн боловч илрөч мэдэгдээг болсон ба энэ хүрээнд үйлдэгдэсн байж болох нутгудам гэмт хэргийн түвшин есөх төвлөтэй.

Энэ талаар тухайн гадаад орнуудай хамтарч ажиллах, нотох баримт авах хувьтойт гаргахад тодорхой барьшээл тулгарч байна.

Мөн ХУУ-ын иргэдээй холбоотой мансуулах бодис хууль бусаар бэлтгэж борлуулсан хэрэг

цөн төгрөгийн бүртгэгдэсэн.

Монол улсын иргэний үнэмлэх, гадаад паспортыг хуурамчар үйлдэх явдал ихэж байгаагас азийн зарим орны иргэд энэ аргаар хуурамч иргэншил олж түүнийээ ашиглан өөр орон руу гарахаа явдал сүүлийн жилүүдэд идэвхижийг байна.

Ийнхүү Монгол Улсад үйлдэгдэг байгаа гэмт хэргийн нэхцэл байдал, слалтаан нь социализмын үеийнхээс ихээхэн өөрчлөгдэх, шинэ төрлийн гэмт хэргүүдийн хувийн жин нэмэгдэж байна.

Дэлхийн аль ч оронд үйлдэгдэг бүх төрлийн гэмт хэргүүд манай улсад үйлдэгдэх боллоо.

Эндээс үзвэл Монгол улс нь үндэстэн дамнансаан гэмт хэргүүдийн үйл ажиллагаагаа явууллах боломж бүхий орны нэг болсон нь харагдаж байгаа ба Ази болон Евро-Азийн томоохон улсуудын дунд өршиж буй газарзүйн байрлал нь тэдний хувьд ашигтай байж болох юм.

Хэрэв бид дээрх хүчин зүйлсүүдийг мэдэрч ажиллаж чадахгүй бол гэмт хэргийн нэхцэл байдал ихэхэн хүнд болох нь тодорхой.

Үүнтэй холбоотойгоор манай улсад нийгэм, эрх зүйн судалын хүрээнд тulgамдаж байгаа чухал асуудлын нэгэнд Криминологийн шинжлэх ухааны онол, судалгааны арга зүйт хөгжүүлэх явдал багтаж байгаа юм.

Энэ асуудал хүчин социалист орнуудыг тухайд ч мен төсөвтэй байгаа гэдэгт итгэлтэй байна. Иймд гэмт хэрэг дээршиж байгаа орчин үед социалист байсан орнууд, хөгжлиөөр буурын оруудад үндэсний Криминологич мэргэжилтнийн балтгах, энэ талын судалгааны байгууллагыг дэмжин бэхжүүлэх, түүний үйл ажиллагааны үр нөлөөг дээшшуулж нийтгийн хөгжлийн серег үр дагаварыг түүгээр дамжуулан оношлох бололцог бурддүүлэхэд дэлхийн хамтын нийзмэлэгийн зүгзэс зориуд анхааран туслах нь хүн төрөлхтний гэмт хэргэтийг тэмцэх нийтлэг эрх ашигт нийцэх гэж узж байна.

Энэ талаар НҮБ болон энэ салбарын олон улсын байгууллагуд цаашид анхааран, санаа тавьж ажиллана гэдэгт найдж байна.

Үүнд энэ хурал дөхөм үзүүлэх нь эргэлзээгүй.

# Өөртөө туслах нь өөрийн хамгаалалтын арга болох тухай асуудалд

ТЕГ-ын Дээд сургуулийн багш, дэд профессор Д.Бат-Өлзий

Тус улсын иргэний эрх зүй дэх өөрийн хамгаалалт хэмээн ойлголт нь шинэ тутам бий болсон зохицуулалт биш бөгөөд аргагүй хамгаалалт болон гарцаагүй байдал гэсэн хам хамжээнүүдийн хэлбэрээр урьд нь иргэний хуулиудад агуулгадаа үйлчилж байсны шинэ Иргэний хуульд нийтийг зохицуулалтад хамааруулж зарим шинэ хэм хэмжээг нэмэн боловсругийн болгосон билээ . Уг ойлголтыг эрх зүйн хамгаалалтын хэлбэр болон аргын алинд нь хамаарах талаар судлаачид өөр өөр байр суурьтай байгаа бөгөөд дийгүүн нь уг ойлголтыг иргэний эрх зүйн хамгаалалтыг аргад хамааруулсан байна.<sup>1</sup> Гэвч өөрийн хамгаалалтыг иргэний эрх зүйн хамгаалалтын хэлбэр гэж узах нь зүйтэй юм. Учир нь иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитрын журмаар буюу хуулиархар олгогдсон байгууллагын үйл ажиллагааны хүрээнд, тэдээрийн оролцотгоор хэрэгжүүлэхгүй эрх зүйн хамгаалалтын хэлбэр гэж узж байгаа бол тэдээрийн оролцоо, туслаалцаагүйзэр уг хамгаалалтыг хэрэгжүүлж нь түүний өөр нэг хэлбэр нь болох юм.

Ойлголтын нийм зерүү тараах болсон нь хоорондоо төсөөтэй боловч өөр өөр ойлголт болох иргэний эрх зүй дэх өөрийн хамгаалалтын арга ба хэлбэрийг тодруулж өгөгүүр хувь тогтоомийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой гэж узажжээр байна.

Тодруулж хэлбэл, Монгол Улсын Иргэний хуулийн 9.3-д "Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ" гэх заасны дараа "Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь зөрчигдсөн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо

хуульд заасан тохиолдолд өөрөө хамгаалалт болно," гэж тусгасан бол илүү оночтой болох байжээ.

Иргэний эрх зүйн өөрийн хамгаалалтын хэлбэрийн хураан дах хамгаалалтын хэд хэдэн аргуудыг хуульд звах эгсний нэг нь өөртөө туслах үйлдэл юм. Өөртөө туслах үйлдлийг өөрийн дур зоргоор, өөрийн хүчээр ямар нэг эрх, шаардлагасаа хангах үйлдэл буюу эрхээхэрэгжүүлэх, хамгаалах анхдагч арга гэж судлаачид тайбларласан байна.<sup>2</sup>

Иргэний хуулийн 12.1-ийн агуулгласаас хавалд өөртөө туслах хэмээн хэм хэмжээний агуулласаа иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийн "эд юмыс эзэмдэж авах, устгах буюу зөвдэх, үүрэг гүйцэтгэхгүй саатуулсаа болон бусад үйлдэл" зэрэг үйлдэл, үйл ажиллагаа бурдуулж байгаа болох нь харгадж байна. Ийм учраас уг ойлголтыг эрх бүхий этгээдээс зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалах зорилгоор хийж буй хуулиар зөвшөөрөн өөрийн сэргээхийн болон бие махбодын хүчийг хэрэглэх талаарх үйлдэл гэх узех үндэстэй байна.

Эдгээр үйлдлүүд нь хууль ёсны шинжилгээний тулд дараах нөхцүүдийн хангасан байх ёстой болох нь хуулийн агуулласаа харгадж байна. Үүнд, нэдүүгээрт, өөртөө туслах үйлдэл хийгдэж бол иргэний эрх зүйн харилцаанд оролцож буй этгээдийн эрх, ашиг сонирхол нь зөрчигдэх буюу эрхээхэрэгжүүлэх хүндэрлэгчдээгүй, тэрээр хамгаалдагчийн хуулийн этгээдийн эдийн болон эдийн бус эрхийг дав ганы шүүх, арбитр хамгаалдагчийн билээ. Иргэд, байгууллагын эрхийг хуульд заасны дагуу цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зэрэг олон байгууллага хамгаалах үргэлжтэй билээ. Гэмт хэргийн шинжтэй үйлдлийн үед хохирог шүүхэд бус юуны өмнө цагдаагийн байгууллагад төлбөр төлгөгчийн хөрөнгийг битүүжилүүлэх, хураалгаар шийдвэр гүйцэтгэлийн албанц тус тус хандах билээ.

Төлөөлөгч уг үйлдлийг хийж болох юм.

Өөртөө туслах үйлдлийг хэрэжүүлэх баат нэхцэл нь эрх зүйн харилцаанд оролцогч нь эрх бүхий байгууллагын туслаамжийг шуурхай авах боломжкүй байнаас хуулиар зөвшөөрөгдсөн үйлдлийг өөрөө биечлэн хийжээс аргагүй болсон байх бөгөөд эрх бүхий байгууллага гэдэгт тухайн зерчил буюу аюулыг таслан зогсоож, зайлзуулах буюу хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх, үүрэг бүхий ямар ч байгууллага, албан тушаалтан байж болно. Харин зарим судлаачид эрх бүхий байгууллагад зөхөн шүүх, арбитрыг хамааруулж, тэдээрийн туслаамжийг шуурхай авах боломжкүй байдал гэдгээ шүүх, арбитрт хандан нэхэмжлэл гарах боломжкүй байхын ойлгоно гэж үзсэн нь<sup>3</sup> үндэслэл мутайт юм. Эдгээр байгууллага нь эрх зүйн маргааныг эзслэж шийдвэрээрээс бус иргэн, хуулийн этгээдийн эдийн болон эдийн бус эрхийг дав ганы шүүх, арбитр хамгаалдагчийн билээ. Иргэд, байгууллагын эрхийг хуульд заасны дагуу цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зэрэг олон байгууллага хамгаалах үргэлжтэй билээ. Гуравдугаарт, өөртөө туслах буй этгээдийн үйлдэл, эс үйлдэхийн нь хуульд заагдсан байна. Иргэний хууль эдгээр үйлдэлд эд юмыг эзэмдэн авах, устгах, зөвдэх, үүрэг гүйцэтгэхгүй саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохор тухайн нэхцэл байдалд тохиоруул

<sup>1</sup> Монголын тэр, эрх зүй.2003.2.3-11 дахь тал. Т.Мөнхжаргалт "Өөртөө туслах нь иргэний эрх зүйн хамгаалалтын арга болох тухай асуудал" Иргэний хууль.Шинэлэг зохицуулалт, УБ., 2004. 15 дахь талд

<sup>2</sup> Т.Мэндсайхан Өөртөө туслах. "Иргэний хууль.Шинэлэг зохицуулалт", УБ., 2004. 7 дахь талд

<sup>3</sup> Н.Баярмаа Иргэний эрх зүйн хамгаалалт ба өөртөө туслах нь. "Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт". 16 дахь талд

хийсан үйлдэл зэргийг хамааруулжээ.

Өөртөө туслах үйлдлийг бидний авч үзсэн дээрх гурван урьдчилсан нэхцэл бурдсан тохиолдолд хэрэгжүүлэх бөгөөд хуульд тухайн үйлдлийг хийждэг тавигдах дараах шаардлагуудыг зааж өгчээ. Үүнд:

1. Өөртөө туслах үйлдэл хийсан этгээд эд юмсыг битгүүмжээш буюу үүргэг бүхий этгээдийг албанад саатуулахаар эрх бүхий байгууллагад нэн даруй мэддэгдэн.

2. Өөртөө туслах үйлдэл нь тухайн нэхцэл байганд тохиолсон хэм хэмжээнээс хэтрэх болохгүй.

Иргэний эрх зүйн харилцаанд орлогчийн эрх, ашиг сонирхлыг хохироосон этгээдийг албанад саатуулах үүргийг ямар ног байгууллагад хуулиар хүзэлгээгүй байна. Харин иргэний эрх зүйн харилцаанд эрх зөрчигч нь эрүүгийн болон захиригаас зөрчлийг давхар бий болгосон тохиолдолд эрх зөрчлийг албанад саатуулахаар зохих байгууллагад мэддэгдэх боломжтой болно.

Зарим зохиогч энэ асуудлыг зөвхөн шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар агаа хэмжээнээс хүрээнд авч үзсэн нь хангальтгүй юм.<sup>1</sup>

Өөртөө туслах хэм хэмжээнд хамаараан үйлдлийг хуульд зааж өгсөн болохыг дээр дурдсан бөгөөд харин эзэрдэг үйлдлийн зөвлөгөөг тайлбарлах нь чухал байна.

**Эд зүйлсийг эзэмдэн авах.** Т.Менжкарал эд зүйлийг эзэмдэн авах үйлдлийг булаакаа ялгах нь зүйтэй гэж үзээд бусдын эд хөрөнгийг хууль бусаар эзэмдэн авбал булаат, өөрийн эд хөрөнгийг эзэмдэн авах нь иргэний эрх зүйн өөртөө туслах үйлдэл болно тэждүгэн уг үйлдэл нь бусдын эзэмшилд үйлдэл бусаар орсон өөрийн эд хөрөнгийг эзэмдэн авах, эсхүл хууль, гэрээний дагуу бусдын эзэмшил, ашиглалтад тодорхой хугацаанд түр байгаа эд хөрөнгөө эзэмдэн авах гэсэн хоёр хэлбэртэд байж болохыг тэмдэглэн

"Эзэмдэн авах нь үүргэг гүйцэтгүүлэгч бусдын эзэмшил буюу ашиглалтад байгаа өөрийн эд.

Ер нь эзэмдэн авсан эд юмс өөртөө туслачийн зөвхөн өөрийн нь, түүчинэн үүргэг гүйцэтгэгчийн байх албагүй бөгөөд гуравдагч этгээдийн ч байж болно. Хөрөнгийн нэн гаралтай салгак авахыг бол өөрт хохирол учрах нь нэгэнт тодорхой болсон нэхцэлдээ үүргэг гүйцэтгүүлэгч /зарим тохиолдолд эрх бүхий этгээд байж болно/ хүч хэрэглэж, түүний эрүүл мэнждээ хохирол учруулахгүйрэй, илэрээ **авах** агаа юм" гэж тодорхойлсон байна.<sup>2</sup>

Харин судлаач Б.Цогнам "Энэ бол шүүд утгаараа энэ наадам өртэй, түүнийгээ өгхөөс зайлсхийдэг гэдгээр шалтгаалан хувиараа агаа хэмжээ авч гэм бууруутайгээ далимдуулан түүний эмчийг устгах, гэмтээ нь харгис хэрэгийг аюултай, хүнгэг бус хандаж байгаагаараа Монгол дур төрхэд тохиорхгүй хүүлийн тохицуулалт юм. Үнэндээ хуулийн энэ тохицуулалт бол "би ч хохирье, чи ч хохир" эш хонсон авахыг хуулиар зөвшөөрсөн заалт тул хуулиас хасах шаардлагатай гэж үзэж байна" гэж бичсэн байна.<sup>3</sup>

Дээрх санаа нь эд зүйлийг ямар зорилгоор ямар нэхцэлд устгах, эвдэх болохыг гүйцэд анхаараагүйгээс гаргаж байгаа алдаатай дүгнэлт гэж үзэж байна.

Харин бид тухайн эд юмстай холбоотойгоор, өөрөөр хэлбэл эд юмсыг зориулалтаар нь ашиглах боломжийг угийн хийгүй бол эрх нь хөнддөгдөх байгаа тохиолдолд түүнийг устгах, эвдэх боломжтой гэж зөв дүгнээд орчин тойрноо аюултай эд зүйлс, амьтан, түүчинэн аюул учирч байгаа болон чуруулж байгаа газрын хаалт саад /хаалга, цонх/ зэргийг хамааруулж үзсэн болно.<sup>5</sup>

Эрдэмтэн Т.Мөнхжаргал эвдэх, устгах нь эд хөрөнгийг эзэмдэн авах, үүргэг гүйцэтгэгчийг эзэмдэн авахаар ортуулахад уг үйлдэл чиглэгдэх бөгөөд энд тохиолдолд сэтгэхүйн болон бийн, түүчинэн мэдээлэлийн /хуураан мэхлээ/ хүч зайлшгүй хэрэглэгдэж таарах бөгөөд тийнхүү эд юмсыг зөвхөн эзэмшил буюу эрхээлдээ тэр оруулсан авч, дараа нь эрх бүхий байгууллагын туслаамжтайгаар тухайн эд юмсын талаараа, эрхээс хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж буй хэрэг юм.

**Эд юмсыг устгах буюу эвдэх.** Эд юмсыг устгах буюу эвдэх гэсэн ойлголтыг хэл зүйн талаас нь тайбларах нь илүүч боловч эрх зүйн талаас нь зөв ойлгох нь чухал байна. Эд юмсыг устгана гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах боломжийг бүрдүүлж буй хэрэг юм.

Болгож байгаа бол эвдэх үед тийм боломжийг багасгах юм.

Судлаач Б.Цогнам "Энэ бол шүүд утгаараа энэ наадам өртэй, түүнийгээ өгхөөс зайлсхийдэг гэдгээр шалтгаалан хувиараа агаа хэмжээ авч гэм бууруутайгээ далимдуулан түүний эмчийг устгах, гэмтээ нь харгис хэрэгийг аюултай, хүнгэг бус хандаж байгаагаараа Монгол дур төрхэд тохиорхгүй хүүлийн тохицуулалт юм. Үнэндээ хуулийн энэ тохицуулалт бол "би ч хохирье, чи ч хохир" эш хонсон авахыг хуулиар зөвшөөрсөн заалт тул хуулиас хасах шаардлагатай гэж үзэж байна" гэж бичсэн байна.<sup>4</sup>

Дээрх санаа нь эд зүйлийг ямар зорилгоор ямар нэхцэлд устгах, эвдэх болохыг гүйцэд анхаараагүйгээс гаргаж байгаа алдаатай дүгнэлт гэж үзэж байна.

Харин бид тухайн эд юмстай холбоотойгоор, өөрөөр хэлбэл эд юмсыг зориулалтаар нь ашиглах боломжийг угийн хийгүй бол эрх нь хөнддөгдөх байгаа тохиолдолд түүнийг устгах, эвдэх боломжтой гэж зөв дүгнээд орчин тойрноо аюултай эд зүйлс, амьтан, түүчинэн аюул учирч байгаа болон чуруулж байгаа газрын хаалт саад /хаалга, цонх/ зэргийг хамааруулж үзсэн болно.<sup>5</sup>

Эрдэмтэн Т.Мөнхжаргал эвдэх, устгах нь эд хөрөнгийг эзэмдэн авах, үүргэг гүйцэтгэгчийг эзэмдэн авахаар ортуулахад уг үйлдэл чиглэгдэх таарах бөгөөд хэрэгжүүлэх эсэр үүргэг гүйцэтгэгч ямар ног үйлдэл хийсэн тохиолдолд эд хөрөнгийг нь устгах, эвдэх юм гэсэн санаа давчвүүлсэн байна.<sup>6</sup>

Хэдийгээр эд юмсыг эзэмдэн авах, үүргэг гүйцэтгэгчийг эзэмдэн авахаар ортуулахад уг үйлдэл чиглэгдэх таарах бөгөөд хэрэгжүүлэх эсэр үүргэг гүйцэтгэгч ямар ног үйлдэл хийсэн тохиолдолд эд хөрөнгийг нь устгах, эвдэх юм гэсэн санаа давчвүүлсэн байгаа билээ.

<sup>1</sup> Н.Баярмал. Иргэний эрх зүйн хамгаалалт ба өөртөө туслах./Иргэний хууль: Шинэлэг зохицуулалт.х.16-17/.

<sup>2</sup> Т.Менжкарал. Фөртөө туслах нь иргэний эрх зүйн хамгаалалтын агаа болох эсүүдэл, Монголын тэр. эрх зүй. УБ., 2003.№ 2 6-7 дахь тал.

<sup>3</sup> Иргэний хууль: Шинэлэг зохицуулалт.УБ., 2004. 21 дахь тал.

<sup>4</sup> Иргэний хууль: Шинэлэг зохицуулалт.УБ.2004. 24 дахь тал .

<sup>5</sup> Д.Бат-Өлзий. Дурдсан зохиол.х.4.

<sup>6</sup> Т.Менжкарал. Өөртөө туслах нь иргэний эрх зүйн хамгаалалтын агаа болох тухай асуудал. Монголын тэр. эрх зүй. 2003 №. 9 дахь тал

## Арбитрын ажиллагааны нууцлалын зарим асуудал

“Монголын Үндэсний Арбитрын 45 жилийн ойд зориулсан “Монгол Улс дахь арбитрын хөгжлийн өвөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр симпозиумд тавьсан илтгэл /2005.04.05/”

“Нууц бол объект, нууцлал бол түүнийг хадлаах, хамгаалах субъектийн хүсэл зориг, үйл ажиллагаа юм”

Өнгөрсөн хавар Сүүл хотод болсон Ази номхон далайн бус нутгийн “bar”-ын холбооны (IPBA) гишүүдийн жилийн узулзат, семинар оролцож байхад хэсэгт өмгөөгчид арбитрын ажиллагааны нууцыг хадлаах, хамгаалах асуудлаар санал болдоо солицож байхтай таарсан юм.

Багш, шинээнд арбитрийн хувьд уг асуудлыг лавшуруулан сонирхлын хүсэл терсен агаад эл асуудлыг манай улсад хэрхэн авч үздэг талаараад тодруулахаас, заплуу судлаачдын анхаарлыг хандуулах үүднээс энэхүү илтгэлээрээс арбитрын ажиллагааны нууцлалын зарим асуудлыг хөндөхийг зорилоо.

Маргандаж талудын нууц хувийн нууцыг хадгалах нь олон жилийн түрүү арбитрын голлох давуу талын нэг байжар ирээтийн бөгөөд энэ нь талууд шүүхэд хядахгүйгээр арбитрыг сонгох нэг нөхцөл нь болж өгдөг билээ. Өнөөг хүртэл олон улсын арбитрын чийгээд ажиллагааны дэгэмждээ нууцлалын асуудал нь арбитрын үндэслэлийн шинжийн тодорхойлогч болсон хэвэрэй байна.

Найман жилийн туршилтээцээ шийдвэрлэгдсэн “жүжигчилсэн” хэмээн нэрлэгддэг Esso v. Plowman-ийн хэрэгт Австралийн дээд шүүхийн гаргасан шийдвэрээс хойш олон улсын хэмжээнд арбитрын ажиллагааны нууц байх зарчмын асуудал судлаачдын маргааны нэг сэдэв болсон бөгөөд арбитрын ажиллагаа нууц байх тухай талуудын шаардлагыг хууль тогтоомж, арбитрын дүрмээр хангайтai.

Я.Цэвэл. “Монгол хэлний төв тайлбар толь” УБ., 1966 он. 391 дэх тал.

2 IPBA Journal. No. 34. June 2004. page-8.

3 Richard W Naismith and Stephanie E Keer, International Private Commercial Arbitration: Expectations and Perceptions of Attorneys and Business People, International Business Lawyer (May 2002)



ХҮҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч  
Д.Цолмон

хамгаалж чадаагыг юм байна гэсэн дүгнэлтэд хүргэсэн байна.

“Нууц” гэдэг үгийг монгол хэлний тайлбар тольд “олонд задруулалгүй, узүүлэхгүй дадалбан зохих юм” гэсэн бол Оксфордын толь бичигт “нууцлал” гэдэг үгийг “нэг тал негээ талаа мэдээллийн нууцыг хадгалахаа гэж итгээн нэхцэл байдлыг хэлнэ” хэмээн утгачлан тодорхойлжсан байна. Үнийн арбитрын агуулгаар авч үзвэл нууцлал нь талуудын эрх шүүрт холбогдох бөгөөд арбитрын ажиллагаа, хуурдааны явцад олж мэдсэн, илэрхий болсон аливаа баримт, мэдээллийн нууцыг хүндэтэн хадгалах тухай асуудал ажээ.

Нууцлал нь арбитрын давуу учиртай. Арбитртайн ажиллагааны явцад илрэснээр толготой баримт болон бусад бичигийн баримтыг нийтийд мэдээлхүүгийн. Өөрөөр хэлбэл, шүүхээс эсрэг байдал зуил нь хувийн нууц, худалдааны нууц, бизнесийн үйл ажиллагаа болон бизнесийн наадам нь. Ур замчлайгаар хамгаалладж байгаа юм. Эндээс арбитрын үйл ажиллагааны явц

болон арбитрын шийдвэрэйг нийтийд мэдээлэхгүй байх асуудал гарч ирэх учиртай.

Арбитрын нууцлал болон уян хаттан байдал нь талуудыг шүүхээс гарах тогтворт мутай, өөрчлөгдмэгтийг шийдвэр /давж заалдах/, цээрлүүлэх шинжтэй хохирол учруулахуйц дааж давшгүй их хэмжээний хариуцлага мэдээс хамгаалахын зэрэгцээ болон нийтээс илэрхийлэх ичгүүртэй шүүмжлэл зэрэгсээ хамгаалдаг гэжээ. Хэдийгээр нууцлалыг маргандрагч талуудад байнга зөрг хүчин зүйл нь болх байдал гэж үздэг боловч зарим хуульч арилжааны практикийн хөгжлийн сергереөр нөлөөлэх стандарт тогтооно гэж үздэг байна’’

Өнөөг хүртэл арбитрын хуралдааны хаалттай явуулснаар түүнтэй холбоотой бүх мэдээлэл нууц байж болно гэж үздэг байсан. Иймээс үндэсний хууль тогтоомж, дүрмээр арбитрын ажиллагааны нууц байх зарчмыг тэр бүр зохицуулгадаагүй. ЮНСИТРАЛын Арбитрын дүрмээр “Талууд өөрөөр тодорхойлж бол арбитрын хуралдааны хаалттай явагдах бөгөөд зөвхөн талууд хүссэн тохиолдолд арбитрын шийдвэрэйг нийтийд сонсноо” гэсэн байна. Олон улсын арилжааны арбитрын тухай хуулийн загварт арбитрын ажиллагаа хаалттай байх, нууц байх талаараа ямар нэг зохицуулалт байхгүй.

Улс орнууд арбитрын дүрмээрээс арбитрын ажиллагааг хаалттай явуулж талаараа зохицуулсан байгад хэдий ч арбитрын ажиллагааг хаалттай явуулснаар нууц хадгалах зарчмыг бүрэн хангажд чадахгүй эхж үздэг. Иймээс эдгэр дүрмээр арбитрын ажиллагааны нууц байх зарчмыг тусгамхай эзэлж байгаа бөгөөд цөөн хэдэн орны шүүхээс арбитрын хэлэлцээрээ нь арбитрын ажиллагааны нууц байх зарчмыг агуулсан байдал гэж үзсэн байна<sup>2</sup>.

Гэлээ ч арбитрын ажиллагааны нууц байх зарчмыг улс орнууд үндэсний хууль тогтоомж, арбитрын дүрэмдээ бүрэн туслаагүй байна. Нууц байх энэ зарчмыг хангаснаар мэдээлэл, нотох баримт зэргийн нууцыг хадгалах, түүний задлакыг хориглох, зөвшөөрөл авах зэрэг үүргийг шинээр бий болгох шаардлагатай болно.

Арбитрын ажиллагааны нууцыг хамгаалах хамгийн анхдагч асуудал бол арбитрын хуралдааны "хаалттай" хэлбэрээр явуулах бөгөөд шийдвэр нь нийтдээ наэлттэй бус байхад оршдог. Хаалттай гэдэг угийг монгол хэлний тайлбар тольд "нийтийн биш байх; нууц байх" хэмээн тайлбарласан байна.

"Хаалттай" гэдэг нь маргаанд хамааралгүй этгээд / гадны хүн/ арбитрын хуралдаанд оролцохгүй байх гэсэн утгыг илрэхийлж байдлаараа шүүхээс ялагдагдаж гэжүүдэл. Харин хаалттай хэлбэрээр шүүх хуралдаан хийх хуулийн зохицуулалттай тохиондолд өөрөөр тайлбарлаждаг нь ойлгомжтой. Одоо "Монгол Улсын Арбитрын тухай хууль"/2003 он-/иэр арбитрын хуралдаан хаалттай явагдах талаар харжан зохицуулсаныг аяч үзье.

"Монгол Улсын Арбитрын тухай хууль"-д шинжилгээ хийвээс уг хуульд хуралдааны хаалттай хэлбэрээр явуулах тухай шүүд заасан зохицуулалт туслаагдагүй байна. Харин уг хуулийн 23 дугаар зүйлд арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлох талаар зохицуулсан бөгөөд талууд арбитрын хуульд нийцүүлжнээс журмыг харилцан тохиролцож тогтоохоор заажэл.

МХЯҮТ-ын Зөвлөлийн Хурлын 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 02 тоот тогтолцооп баталсан "Арбитрын хэрэг шийдвэрлэг дүрэм"-ийн 22 дугаар зүйлээр арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлох талаар зохицуулсан байна. Үүнд, арбитрын ажиллагаа явуулах журмын талууд харилцан

тохиролцно. Арбитрын бүрлэдэхүүн арбитраас хэргийн материалын хүлээн авсан даруйд баримт бичгийн үндэслэл талуудыг байгуулан арбитрын ажиллагааны журмыг тодорхойлно. Энэ журамд дараахаа зүйлийг тусгана гэжээ. Үүнд:

а/ талуудын албан ёсны нэр, хаяг;  
б/ маргааны агуулга;  
в/ арбитрын хураамж;  
г/ тогтоо ёстой асуудлууд;  
д/ арбитрчдын нэр, хаяг;  
е/ арбитрын ажиллагаа явуулах газар;  
ё/ арбитрын ажиллагаа явуулах хэл;  
ж/ арбитрын ажиллагаанд хэрэглэх эрх зүй.

"Монгол Улсын Арбитрын тухай хууль" Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэмд арбитрын хуралдааны ямар хэлбэрээр тухайлбал, хаалттай явуулах талаар зохицуулалт туслаагдаж байна. Энэ нь сонирхогт иргэн, хэвлэл мэдээллийн байгууллагас арбитрын хуралдаанд суух хүснэгтэй үед тунд "хаалттай" явагдах ёстой гэдэг үндэслэлээр хуралдаанд суулгахас татгалзах хууль зүйн боломжгүйсгэдэж байгааг цаашид анхааруштai.

Хэрэг шийдвэрлэх дүрмийн 40 дүгээр зүйлийн 40.13-т "Арбитрчид тусгайлан зөвлөлдөхдөө хаалттай хуралдаан хийх ба зөвлөлдөх тасалгааны нууцыг чандлан хадгалаан" гэсэн байна. Энэ нь арбитрын хуралдааны хаалттай хэлбрүүлээр бус харин арбитрын бүрлэдэхүүн шийдвэр гаргах хуралдааны хэлбэрэйн зохицуулалт гэдэг нь тодорхой билээ.

Энд нэмж хэлэхэд 1995 оны "Гадаад худалдааны Арбитрын тухай" хуучин хуулийн 13 дугаар зүйлд арбитрын хуралдаан явуулах хэлбэр, нууц хадгалах тухай зохицуулсан байх бөгөөд 13 дугаар зүйлийн 13.1-д "Арбитрын

хуралдааныг нээлттэй явуулна", 13.2-т "Хэргийн нотох баримт нь төр, байгууллага, хувь хүний болон талуудын худалдааны нууцтай холбогдолтой бол арбитр өөрийн санаачилгаар бууж талуудын хүснэгтээр хуралдааны хэллэгийг явуулж болно. Энэ тохиолдолд шийдвэрлийн и Songno", 13.3-т "Арбитрын хуралдааны үед илэрхий болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг хэрэг шийдвэрлэх бүрлэдэхүүн болон хуралдаанд оролцогчид хадгалаан үзүүлэх гэж зохицуулж байсан байна.

Нууц байх зарчмыг хангах өөр нэг арга бол арбитрын ажиллагааны явцад олж мэдсэн аливаа мэдээлэл, нотох баримтын талаарх мэдээллийг арбитрын бүрлэдэхүүн болон хуралдаанд оролцогчид задруулж байх, гуравдагч этгээдэд талуудын зөвшөөрөлгүйгээр олгохыг хориглох явдал байж болдог.

Нууц нь хадгалагдах ёстой мэдээлэл, материалыг ерөнхийд нь "арбитрын ажиллагаа болон маргаантай холбоотой баримт болон бусад мэдээлэл" гэж тохимольсон байна. Зарим үед нууц байлагх мэдээллийг нэг бүрчлэн тодруулсан байдал байна. Жишээ нь, талуудаас гаргасан нотох баримт, гэрчийн мэдүүлэг, бичгэн ба аман тайлбар, арбитрын ажиллагаа болсон газар, арбитрчдын талаарх мэдээлэл, шийдвэрлийн агуулга, талуудын хоорондох харилцаа холбоо, худалдаа, арилжаваны нууц гэх мэт. Түүнчлэн нууцтай холбоотой асуудлын ангилж болох юм. Жишээ нь, нууц байх мэдээлэл, нууц хадгалааны үүрэгтэй этгээд, нууц залдах, нийтэд мэдээлэхийг зөвшөөрөх тохиолдолд зэргийг тусгайлан нарийвчлан заах болно.

Нууц хадгалааны үүрэгтэй этгээд нь арбитрчид, байнгын арбитрын ажилтнууд, талууд, тэдгээрийн төлөөлөгчид, гэрч, шинжээч, хуулийн зөвлөх зэрэг хүмүүс байх болно. Эдгэр хүмүүс нэг адил үүрэг хүлээхгүй тул

<sup>1</sup> IPBA Journal, № 36, December 2004, page-10.

<sup>2</sup> И.С.Эзикин "Олон улсын арилжаваны арбитрт маргааныг зөвлөрлийн замаар зохицуулах нь" "Үндэсний арбитр" 2004 он. №2.32 дахь тал

<sup>3</sup> Мен тэнд

арбитрчид болон талуудын төлөөлгөчид, магадгүй гэрч күнүц хадгалах тухай хэлэлцээрт гарын үзүүлж болох юм. Мен гэрч дуудах байгаа тал уг гэрчийт талуудтай адил үүрэгтэй болохыг баталж болно. Нууц хадгалах хугацааг хуулиар тогтоож өгөх ч боломжтой гэж үздэг. Нууцад хамаараах мэдээллийг нийтдээ мэдээлэл, задлагад тохиолдол байж болох бөгөөд үүнд талууд зөвшөөрсөн; мэдээлэл нийтийн эрх ашигтай холбоотой; хууль тогтоомж, эрх бүхий этгээд уг нууцыг задлажишиш шаардсан; талуудын хууль ёсны эрх ашигийг хамгаалахад уг нууцыг задлах шаардлагатай зэргийг оруулсан байна. Дээрх тохиолдуудын зарим нь тодорхойгүй байж болох ч "нийтийн эрх ашиг" гэдгийг илүү анхаарах хэрэгтэй юм.<sup>1</sup> Энэ асуудал дээр уг мэдээллийг нийтдээ задалсаннаар урчах хохирол болон задлахгүй байнаар нийтийн эрх ашиг хэрхэн хохирохыг харьцуулж үзэх шаардлагатай.

Хуулиар нууц задлах чейийг зохицуулж болох бөгөөд хэрэв мэдээллийг арбитрын ажиллагааны явцад задлах шаардлагатай бол уүнийг арбитрын бүрзэлжээн болон нөгөө талд мэдэгдэх ёстай. Харин арбитрын ажиллагаа дууссаны дараа нууц задалсан бол нөгөө талд энэ тухай мэдэгдэхэд хангальгтай гэнэ.

Арбитрын шийдвэрийг нууц байгахгүй зэрэгээ зарим байнтын арбитр нь шийдвэрлэсэн хэрэг маргааны статистикийг нийтийлэх, талуудын нэрийт ил гаргаглуйгээр мэдээлэл хийдэг байна.

"Монгол Улсын Арбитрын тухай хууль"-ийн 32 дугаар зүйлд нууц хадгалах тухай зохицуулсан байх бөгөөд 32 дугаар зүйлийн 1-д "Арбитрын бүрзэлжээн" болон зохицгид арбитрын ажиллагааны явцад тодорхой болсон тэр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй" гэжээ. Түүчинлан Арбитрын хэрэг шийдвэрлэх талуудад ажиллагаанд зохицгид арбитрын ажиллагааны явцад тодорхой болсон тэр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй" гэжээ. Түүчинлан Арбитрын хэрэг шийдвэрлэх талуудад ажиллагаанд зохицгид арбитрын ажиллагаанд оролцсон Арбитрын институтын нарийн бичгийн дарга нарын газрын холбогдох хумүүс арбитрын ажиллагаанд оролцсон бүрхэгтэй ялангуяа талууд, гэрч, шинжээч болон бусад нотох баримтын талаарх нууцыг хадгалах үүрэгтэй. Арбитрын ажиллагаанд оролцож байгаа этгээд арбитрын

юм. Арбитрын хуулийн нууц хадгалах тухай энэхүү зохицуулалтыг арбитрын ажиллагааны нууцыг хамгаалах харилцааг бүрэн дүүрэн зохицуулж чадаагүй учир дадалгатай гэж үзж болох юм. Арбитрын ажиллагааны явцад тодорхой болсон ... нууцыг хадгалах гэдгийн нууцыг тухай багц хуулийн хурээнд лавч үзж үү гэдэг асуудал гарахын зэрэгцээ ИХШХШТК-ийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Хаалттай шүүх хуурааданы явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлийн мэдэгдсан тэр, байгууллага, хувь хүний нууцыг шүүгч, шүүх хуурааданы оролцож задруулж болохгүй" гэсэн зохицуулалттай адил хэмжээнд байна.

Харин Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн 1 дүгээр зүйлийн 6-д "Монголын Үндэсний Арбитр арбитрын үйл ажиллагааны нууцыг хадгалах, арбитрын үйл ажиллагааг хараат бус, шударгаар, түргэн шуурхай явуулна." төхзаасан нь арбитрын ажиллагааны нууцлалын агуулгад нийцэхүүчийг байна. Түүнчлэн арбитрчваар томилогдох тохиолдолд тухайн арбитрич "Зөвшөөрсэн болон Хараат бус байдлын талаарх Мэдэгдэл"-д хариу өгөх ёстай байдал баагаа угзэр ч бас арбитрын ажиллагааны нууцыг чанд сахих үүрэг бий болж байдал гэж үзж болох юм.

Арбитрын ажиллагааны нууцлалын талаар уншиж байхад энэ асуудлын хурээ нийлээд өргөн болголтой. Тухайлбал, ХБНГУ-ын Арбитрын Институттээ гаргассан "Арбитрын дүрэм"-ийн 43 дугаар зүйлд нууц хадгалах тухай "арбитрын бүрзэлжээн", талууд, арбитрын ажиллагаанд оролцсон Арбитрын институтын нарийн бичгийн дарга нарын газрын холбогдох хумүүс арбитрын ажиллагаанд оролцсон бүрхэгтэй ялангуяа талууд, гэрч, шинжээч болон бусад нотох баримтын талаарх нууцыг хадгалах үүрэгтэй. Арбитрын ажиллагаанд оролцож байгаа этгээд арбитрын

ажиллагааны нууцыг хадгалах үүрэгтэй. Арбитрын Институт нь арбитрын ажиллагаанд оролцсон этгээдийн албан нэр, хаяг болон тодорхой мэдээллээс бусад статистик үзүүлэлтийг нэгтгэсэн арбитрын ажиллагааны талаарх мэдээллийг нийтэлж болно" гэж заасан байна.

Арбитрын шийдвэрийг нийтийлэх эсэх асуудал дүрмээр зохицуулагдаж байгаа бөгөөд манай улсын арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн 44 дүгээр зүйлийн 9-д "Арбитрын шийдвэрийг талууд болон арбитрын албан ёсны зөвшөөртэйгээр хэвлэн нийтэлж болно. Аливаа хэвлэлд талуудын нэрс, хууль ёсны төлөвлөгч, арбитрчид бусад байгууллагын тухай мэдээллийг нийтилжүүг" гэжээ. ХБНГУ-ын Арбитрын дүрмийн 42 дугаар зүйлд манай улсынхтай адил агуулгаар тусгассан хэдий ч "арбитрын ажиллагааны талаарх бусад тодорхой мэдээллийг нийтилжүүг" хэмээн тодотож өгсэн байна.

Арбитрын ажиллагааны нууцын тухай асуудал арбитрт хандсан зуучлалын үйл ажиллагаанд ч мөн адил анхаарал хандуулдаг байна. Хонг Конгийн хуулиар арбитр нь эвлээрүүлэх ажиллагаанд оролцож болохыг зөвшөөрсэн байдал байна.<sup>2</sup> Маргаан шийдвэрлэх сонголтот аргуудыг хөгжүүлэх тал дээр манай улс анхаарал хандуулж эхлээд байгаа бөгөөд энд нууцлалын асуудлыг ч давхар үзэх хэрэгтэй юм.

Эвлээрүүлэх ажиллагаанд оролцсоноор зуучлагч этээд болон талуудад шүүх, арбитрын ажиллагаатай холбоотой хэд эхэн үүргийг хүлээдэг байна.

Тухайлбал, талууд аваргаар тохиолцогүй бол эвлээрүүлэх ажиллагаанд оролцсон зуучлагч тухайн маргааны арбитраар шийдвэрлэхдээ арбитрч, аль изг талын төвлөлгийг буюу грэчээр оролцох эрхгүй. Талууд маргааны шүүх болон арбитраар шийдвэрлэх тохиолдолд эвлээрүүлэх ажиллагааны явцад маргаан шийдвэрлэх зорилгоор талууд болон зуучлагчийн хэлсэн санал,

<sup>1</sup> И.С.Эзикин "Олон улсын арилжааны арбитрт маргааны эвлээрлийн замаар зохицуулах нь" "Үндэсний арбитр" 2004 он №2, 32 дахь тал.

<sup>2</sup> Төрийн, байгууллагын, хувь хүний нууцин тухай хуулиуд 1995 оны 7 сарын 1-нээс эхэн үйлчилж байгаа.

саная ба түүнийг нөгөө тал зөвшөөрсөн зэрэг фактыг нотлох баримтны чанартайгаар дурдаж, ашиглак болдоггүй байж шаардлагатай.

Иймээс талууд маргаанаа звлэрлийн замаар шийдвэрээгүй тохиолдолд тэдний өөрсдийн хэлсэн саная, саная нь өөрийн нь зорг дараагийн ажиллагаанд ашиглалгахгүй гэгдтэй бүрэн итгэлтэй байж, тэдгээрийн хооронд итгэлцийн харицаа бий болох бөгөөд энэ нь маргааныг шийдвэрлэхэд зөрж нөлөө узүүлэх учиртай.

Хэрэв звлэрүүлэх ажиллагаа звлэрлээр дуусуулж чадалгүй талууд шүүх, эсхүн арбитрын ажиллагааг эхэлсэн бол звлэрэх тухай хүснэгт, саная нь ул саналын гаргасан талын эсрэг үйлийг болно. Энэ нь звлэрүүлэх ажиллагааны явцад идэвхтэй оролцож байсан талуудын хувьд таагүйгээр нөлөөлж звлэрүүлэх ажиллагааны ашигтай талын бууруудаг ажээ. Энэ бэрхшээлтийн асуудлыг ЮНСИТРАЛ-ын Звлэрүүлэх ажиллагааны дүрмийн 20 дугаар зүйлд зохицуулж таажигүйгээр нөлөөлж звлэрүүлэх ажиллагааны явцад талаар мэдэгдэж болно. Мэдээлэл нүүц тохиолдолд зонхижуулж мэдээллийг нөгөө талд мэдгэгдхүй байж болно гэжээ.

Түүнчлэн 11 дүгээр зүйлд арбитрын ажиллагаанд оропцож тухай зохицуулахаадаа "Талууд өөрөөр тохиолцоогой бол зуучлагч шүүх, арбитр болон марган шийдвэрээс аливаа ажиллагаанд шүүч, арбитрч, шинжээч болон талуудын хуулийн зөвлөх, өмөвлигчөөр оролцохгүй. Хэргэгэх хуулиар өөрөөр заагаагүй эсвэл талууд бичгээр өөрөөр тохиолцоогой бол шүүх, арбитр, марган шийдвэрээх ажиллагаанд гэрийн этгээдээр оролцохгүй байхаар тоогооюу."

а/ Маргааны асуудлаар звлэрэх талаар нөгөө талын гаргасан санай ба үзл болод;

б/ Эвлэрүүлэх ажиллагааны явцад нөгөө талын гаргасан тайлбар;

в/ Эвлэрүүлэгчийн гаргасан санал;

г/ Эвлэрүүлэгчийн гаргасан звлэрэх тухай саналын нөгөө тал хүлээн авах хүснэгтэй байсан тухай.

Хэрэв талууд звлэрүүлэх ажиллагааны дүрмийн хэрэглээгүй буюу ЮНСИТРАЛ-ын дүрмийн 20 дугаар зүйлтэй адил зохицуучийн нөхцөл агуулаагүй дүрмийн хэрэглэсэн бол дээр дурдсан шийдвэрээтийн учирч болно.

Талууд 20 дугаар зүйлтэй адил зохицуулалттай дүрмийн хэрэглэсэн ч нотлох баримттай холбоотой хэлэлцээр бүрэн үйлийн чадах эсэх нь эргээзэтэй. Ийм нөхцөл талуудад тулах үүднээс звлэрүүлэх ажиллагаанд эмне нь хэрэглэсэн нотлох баримтыг шүүх, арбитр хэрэглэхгүй байхар зохицуулж байна.

Манай улсын тухайд MYXAUT-ын Звлэрлийн хурлын 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 02 тоот тогтооюор "Арбитрын Зуучлагчийн ажиллагааны ажиллагааны дүрэм" үйлийн байна. Уг дүрмийн 10 дугаар зүйлд нүүц хадгалах тухай зохицуулжээ. Тухайлбай, зуучлагчид зуучлагчийн ажиллагааны ўеэр эрх үүргээ хэрэгжүүлж явдлаа олж мэдсэн хувь хүн, байгууллага, төрийн аливаа нүүцлийн хандлан хадгална. Хэрэв талууд өөрөөр тохиолцоогой бол зуучлагчийн ажиллагааны тухай аливаа мэдээлэл нүүц байна. Зуучлагч маргаантай холбоотой мэдээллийг аль нь талаар хүлээн авсан тохиолдолд нөгөө талд энхүү мэдээллийн талаар мэдэгдэж болно. Мэдээлэл нүүц тохиолдолд энхүү мэдээллийг нөгөө талд мэдгэгдхүй байж болно гэжээ.

Түүнчлэн 11 дүгээр зүйлд арбитрын ажиллагаанд оропцож тухай зохицуулахаадаа "Талууд өөрөөр тохиолцоогой бол зуучлагч шүүх, арбитр болон марган шийдвэрээс аливаа ажиллагаанд шүүч, арбитрч, шинжээч болон талуудын хуулийн зөвлөх, өмөвлигчөөр оролцохгүй. Хэргэгэх хуулиар өөрөөр заагаагүй эсвэл талууд бичгээр өөрөөр тохиолцоогой бол шүүх, арбитр, марган шийдвэрээх ажиллагаанд гэрийн этгээдээр оролцохгүй байхаар тоогооюу."

Ю Н С И Т Р А Л -ын звлэрүүлэх ажиллагааны дүрмийн 20 дугаар зүйлтэй адил зохицуулалтад байгаа арбитр, шүүчийн шийдвэрээгээд гаргаж үл болох нотлох баримтыг тухай заалтас Манай улсын "Арбитрын Зуучлагчийн ажиллагааны дүрэм"-д оруулжэгэх чигдах шийдвэрээх ажиллагаанд сонготлогт аргуудыг хэлжүүлэхэд

зөрэг нөлөө узүүлэх нь лавттай.

Арбитрын ажиллагааны нүүц хадгалах тухай ярж байгаа нэхцэлд хариуцлагын асуудал зайншгүй яригдах учиртай. Олон улсын арилжааны арбитрын ЮНСИТРАЛ-ын Хуулийн загварыг бэлдэх үед арбитрчдын хариуцлагын асуудлыг уг загварт оруулаагүй байна. Үндэслний хуулиар ялангуяа загвар хуулийг хэрэглэсэн олон хуулиар арбитрчдын хариуцлагын тухай зохицуулалт намэгдсэн байна. Англо-саксоны эрх зүйн бүйлийн орнуудад арбитричийг шүүгчтэй адилтган үзэд бол эх газрын эрх зүйн бүйлийн орнууд арбитричийг гэрээнд үндээн дээр эрх үүрэг нь үүсдэг этгээд гэжүүлэж. Гасан хадийг ч эрх зүйн нийг бүлд энд талаар ялгаатай хандлага байдгийг тэмдэглэх нь эйтгэйгээж.

